



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭСЭ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



JFPR
Japan Fund for Prosperous and
Resilient Asia and the Pacific



ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг
гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд гүйцэтгэв.

Эмхэтгэсэн: Хууль зүйн доктор /Ph.D/, дэд профессор
хурандаа Б.Алтангэрэл /ДХИС-ийн
ЭШНХ-ийн ШШГС төвийн эрхлэгч/

Улаанбаатар хот

2023 он

Захиалагч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Редактор:

Н.Болормаа *Сэтгэл судлаач нийгмийн удирдлагын магистр*

Д.Өлзийсүрэн *Нийгмийн ажлын удирдлагын магистр*

Цаасны хэмжээ: 176x250

Хэвлэлийн хуудас: 10.3

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	7

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТАД ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН АГУУЛГА

9

Үндсэн хууль	9
Иргэний хууль	14
Эрүүгийн хууль	17
Зөрчлийн тухай хууль	23
Гэр бүлийн тухай хууль	28
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	31
Хүүхдийн эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомж	36
Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль	43
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль	45

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БҮЙ ХОРИГДОЛД ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

49

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	49
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	53
Хулгайлах, дээрэмдэх гэмт хэрэг	56
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	63
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	68

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЭЛЖ ЯЛТАНД ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

73

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэрэг	73
Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг	77
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	83
Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг	90

Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг	92
Хууль бусаар ан агнах гэмт хэрэг	97
Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг	100

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ЭДЭЛЖ БҮЙ ЭТГЭЭДЭД
ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА** **103**

Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил	103
Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил	106
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	111
Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих.....	114
Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	116
Хүүхдийн эрхийг зөрчих	118
Бэлгийн дарамт учруулах	119

**ТАВДУГААР БҮЛЭГ. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ
ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ** **120**
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ **123**

ӨМНӨХ ҮГ

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог билээ.

Энэхүү зорилгыг хангах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд сөрөг зан үйлийг засах, нөлөөлөх үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг.

Зан үйлд нөлөөлөх сургалтын зорилго нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд үйлдсэн хууль бус үйлдлийн хор уршгийг ойлгуулахад чиглэх ба эцсийн дүнд нийтээр дагаж мөрдөж буй эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээг сахин мөрддөг, нийгэмшсэн бие хүн болж төлөвшүүлэхэд чиглэх учиртай.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж буйн нэг нь энэхүү зан үйлд нөлөөлөх сургалтыг явуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, удирдлага, зохион байгуулалтаар хангах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, багшлах хүний нөөцийн бэлтгэхэд онцгой анхаарч байгаагийн жишээ нь энэхүү сургалтын гарын авлага юм.

Энэхүү сургалтын гарын авлага нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын А/103 дугаар тушаалаар “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам”-д тусгагдсан хорих ял эдэлж буй хоригдол, баривчлах шийтгэл эдэлж буй этгээд, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зайлшгүй шаардагдах хууль, эрх зүйн мэдлэг олгоход чиглэгдэн боловсрогдсон билээ.

Гарын авлагыг журамд заагдсан сэдэв, хөтөлбөрийн хүрээнд боловсруулснаас гадна хуулийн зүйл, заалтыг аль болох энгийнээр тайлбарлахыг зорьжээ. Түүнчлэн гарын авлагад эрх зүйн сургалтыг явуулахад шаардагдах арга зүйг тайлбарлаж оруулсан нь сургалт явуулах алба хаагчдад чухал мэдээлэл болжээ.

Сургалтын гарын авлагад тусгагдсан хичээлийн агуулга нь жишиг тул та бүхэн сэдвийн агуулгад нийцүүлэн, лекц, кейсийг баяжуулан заах бүрэн

боломжтой гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Энэхүү сургалтын гарын авлага нь хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын зан үйлд нөлөөлөх эрх зүйн сургалт явуулах ширээний ном болно гэдэгт бүрэн итгэж байна.

Хүндэтгэсэн: ШШГЕГ-ын Сургалт,
нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн дарга,
хурандаа Ч.Цэнгэлбаяр

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Авлига	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олжавах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;
Бэлгийн дарамт	Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг;
Гамшиг	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;
Гэр бүл	Гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд;
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;
Гэмт хэрэгтэй тэмцэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулах;
Гэм буруу	Тухайн этгээдээс өөрийнхөө эрх зүй зөрчсөн зан үйл, хор уршигт хандсан сэтгэцийн хандлага;
Гэмт хэргийн хохирол	Эд хөрөнгийн шинжтэй, мөнгөн дүнгээр илэрхийлж болохуйц гэмт хэргийн хор уршгийн төрөл;
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис	Донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны НҮБ-ын Конвенц, "Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай" 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг;

Нийтийн хэв журам хамгаалах	Гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагаа;
Согтууруулах ундаа	Хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, 2 хувиас дээш хатуулагтай нэршлээс үл хамаарсан бүх төрлийн архи, дарс, шар айраг зэргийг;
Хүчирхийллийн болзошгүй эрсдэл	Гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг;
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт;
Цуглаан	Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг;
Жагсаал	Иргэд хот суурины гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг;
Олон нийтийн аюулгүй байдлыг хангах	Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, улс орны эрх ашигт ноцтой хор уршиг, хохирол учруулж болзошгүй аюулыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааг;
Замын хөдөлгөөнд оролцогч	замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигч
Үйлдэл	Хүн, хуулийн этгээдийн идэвхтэй байдал, үйл хөдлөл;
Эс үйлдэл	Тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болох;
Хоригдол	Хорих ял эдэлж буй ялтан;
Ялтан	Шүүхийн шийтгэх тогтоолоор хорихоос өөр төрлийн ял эдэлж буй этгээд;

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТАД ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН АГУУЛГА

СЭДЭВ 1. ҮНДСЭН ХУУЛЬ

Үндсэн хууль нь аливаа улсын төр, засаглалын тогтолцоо, хүний эрх, эрх чөлөө зэрэг үндсэн асуудлыг баталгаажуулж өгсөн эрх зүйн дээд хүчин чадал бүхий ардчилсан эрх зүйт төрийн суурь зарчмуудын бүрдэл байдаг.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ба хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Үндсэн хууль дээр дурдсанчлан олон тулгуур асуудлыг зохицуулж өгсөн тул хоригдол, ялтан, баривчлагдсан этгээдийн тухайд хүний эрх, эрх чөлөө, хүлээх үүргийн талаар заах нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөө, үүргийг талаар хуульчилсан бөгөөд хорих ял эдэлж буй хоригдол, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан, баривчлагдсан этгээдэд иргэний эрх, эрх чөлөөг хэрхэн эдлэх талаар авч үзье. Үүнд:

Д/д	Иргэний эдлэх эрх, эрх чөлөө	Хоригдол	Ялтан	Баривчлагдсан этгээд
1.	Амьд явах эрхтэй.	Шүүхийн шийдвэрээр ямарваа нэгэн ял, шийтгэл эдэлж буй албадлагын арга хэмжээ авагдсан этгээд амьд явах эрхээ бүрэн эдлэх учиртай.		
2.	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;	Хорих болон баривчлагдсан этгээдийг хорьж буй орчин нөхцөл нь хүний наад захын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц байхаар тоноглогдсон байна. Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтны тухайд ял эдлэх орчин нөхцөл нь эрүүл, аюулгүй байх ёстой.		
3.	Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.	Хоригдол итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан эд хөрөнгийн шинжтэй харилцаанд оролцох эрхтэй.	Ялтан бие даан эд хөрөнгийн шинжтэй харилцаанд оролцох эрхтэй.	Баривчлагдсан этгээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан эд хөрөнгийн шинжтэй харилцаанд оролцох эрхтэй.

4.	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;	"Хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих", "Хоригдолд хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгоно", "Хоригдолд хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс олгоно".	Шүүхийн шийдвэрээр нийтэд тустай ажлыг ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг албадан хөдөлмөрлүүлнэ.	ШШГТХ-ын 145.2.9-д захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх ажлыг зохион байгуулна.
5.	Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;	ШШГТХ-ын 210.1.8-д хоригдол урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох эрхтэй.	Ялтан, баривчлагдсан этгээдийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу тусламж, дэмжлэг авах эрхтэй.	
6.	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;	Хоригдол эмнэлгийн тусламж авах эрхтэй ба эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө, шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх үүрэгтэй.	Ялтан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдсэний дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах бүрэн эрхтэй.	Баривчлагдсан этгээдийн эрүүл мэндийн үйлчилгээг тухайн баривчлах байр, бусад нарийн мэргэжлийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулна.
7.	Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.	Хоригдол өөрийн зардлаар их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад хамрагдах эрхтэй. Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулна.	Ялтан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдсэний дагуу боловсролын үйлчилгээнд хамрагдах бүрэн эрхтэй.	Баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг баривчлах байр зохион байгуулна.

8.	Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;	Хоригдол, холбогдох зардлаа өөрөө хариуцаж хорих байгууллагаас тогтоосон газарт шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих эрхтэй. Ялтан, баривчлагдсан этгээдийн хувьд энэхүү эрх мөн адил хэрэгжинэ.		
9.	Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ;	<p><i>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд:</i> 1. Хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй.</p> <p><i>Улсын их хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй.</p> <p><i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Гэмт хэрэг үйлдэж, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.</p>	<p><i>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд:</i> 1. Эрүүгийн гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.</p> <p><i>Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Гэмт хэрэг үйлдэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.</p> <p><i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Гэмт хэрэг үйлдэж, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.</p> <p>Ялтны тухайд нэр дэвшихийг хориглосон боловч сонгууль өгөх эрх нь нээлттэй байна.</p>	Зөрчлийн улмаас баривчлагдсан хүн сонгууль өгөх эрхтэй.

10.	Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй;	Улс төрийн намын тухай хуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй гэж заасан байдаг хоригдол нь сонгуулийн эрхгүй тул энэхүү эрхийг эдлэх боломжгүй байдаг.	Ялтан, баривчлагдсан этгээдийн тухайд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулахгүйгээр эрхээ эдлэх боломжтой юм.
11.	Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй;	Хоригдол, ялтан, баривчлагдсан этгээд гэрлэх болон гэр бүлийн харилцаанд оролцох эрхтэй.	
12.	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй;	Хоригдол хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.	Ялтан, баривчлагдсан этгээд аливаа асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.
13.	Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.	Хоригдол хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах эрхтэй.	Ялтан, баривчлагдсан этгээдэд энэхүү эрх мөн адил хамаарна.

14.	Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй;	Хоригдол өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхтэй.	Ялтан, баривчлагдсан этгээдэд энэхүү эрх мөн адил хамаарна.	
15.	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;	Хоригдол хорих ангийн дотоод журам, цагийн хуваарьт нийцүүлэн шашны зан үйл үйлдэх эрхтэй.	Ялтан шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй.	Баривчлагдсан этгээд баривчлах байрны дотоод журам, цагийн хуваарьт нийцүүлэн шашны зан үйл үйлдэх эрхтэй.
16.	Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй;	Хоригдол хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах эрхтэй ба харин хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлахыг хориглоно.	Ялтан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхтэй.	Баривчлагдсан этгээд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ба харин жагсаал, цуглаан, суулт хийхийг хориглоно.
17.	Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй;	Хоригдол өөрт холбогдох асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.	Ялтан энэхүү эрхээ эдлэх бүрэн боломжтой.	Баривчлагдсан этгээд өөрт холбогдох асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

18.	Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.	Хоригдлын хувьд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад энэхүү эрх бүрэн хязгаарлагдана.	Ялтны хувьд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр зорчих эрхийг эдлэхээс гадна гадаадад зорчих эрхийг хязгаарлана.	Баривчлагдсан этгээдийн хувьд баривчлах шийтгэл эдлэх явцад энэхүү эрх бүрэн хязгаарлагдана.
-----	--	--	---	--

Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн болон журамт үүргийг биелүүлэх үүрэгтэй.

Үндсэн үүрэг	Журамт үүрэг
Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;	Хөдөлмөрлөх;
Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;	Эрүүл мэндээ хамгаалах;
Хуулиар ногдуулсан албан татвар төлөх;	Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх;
Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.	Байгаль орчноо хамгаалах.

Хэрэв Үндсэн хуульд заасан үүргээ иргэн биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

Хяналтын асуулт:

1. Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээдэд иргэний эдлэх эрх, эрх чөлөөний ямар хязгаарлалт хүлээх вэ?
2. Ял эдэлж буй байдал нь тухайн хүнд сөрөг үр дагаврыг авчирч болох вэ?

СЭДЭВ 2. ИРГЭНИЙ ХУУЛЬ

Иргэний хуулиар хүний амьдралд байнга тулгарах бага жижгээс эхлээд томоохон хэмжээний олон төрлийн харилцааг зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, хүн өглөө ажилдаа нийтийн тээврээр зорчих, дэлгүүрээр үйлчлүүлэхээс эхлээд иргэд хооронд төдийгүй, бусад төрийн байгууллага, хуулийн

этгээдийн хооронд үүссэн ихэнх харилцаа иргэний хуулиар зохицуулагдаж байдаг.

Иргэний хуулиар нэгдүгээрт, эдийн баялагтай холбоотой харилцаа, хоёрдугаарт, эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Эдийн баялагтай холбоотой харилцаа гэдэг нь юуны өмнө биет эд юмс, эдийн засгийн мөн чанарын хувьд мөнгөний шинжтэй буюу үнэлэгдэх агуулгатай харилцаа ордог. Харин эдийн бус баялагтай холбоотой харилцаанд оюуны өмч, мэдээлэл, иргэний нэр төр, хуулийн этгээдийн нэр зэрэгтэй холбоотой харилцааг хамааруулж ойлгоно.

Иргэний хууль нь нийгэмд зохицуулах болон хамгаалах үүрэг гүйцэтгэдэг.

Зохицуулах үүрэг нь нийгэмд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэлт, мөнгөний хэвийн эргэлтийг зохион байгуулахын зэрэгцээ эдгээр үйл ажиллагааг явуулахад үүссэн эрх зүйн зөрчлийг арилгахад үйлчилдэг.

Хамгаалах үүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эдийн болон эдийн бус баялгийн эрхийг хамгаалах явдал бөгөөд зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна. Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитрын хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлэх ба иргэний эрхийг дараах аргаар хамгаалдаг. Үүнд:

1. Эрхийг хүлээн зөвшөөрөх;
2. Эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх;
3. Хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;
4. Учруулсан хохирлыг арилгуулах;
5. Эдийн бус гэм хорыг арилгуулах;
6. Хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;
7. Бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох;
8. Иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох;
9. Өөртөө туслах;
10. Хуулиар тогтоосон бусад арга.

Иргэний чадвар, чадамж:

Иргэн гэсэн ойлголт нь өргөн агуулгатай бөгөөд иргэний харилцаанд оролцохдоо бусдаас ялгагдах нэр, харьяалал, нас, гэр бүлийн байдал, хүйс, эрүүл мэндийн байдал, оршин суугаа газар гэсэн онцлог хувь шинжийг хамааруулан авч үздэг.

Иргэний эрх зүйн чадвар гэдэг нь иргэн, иргэний эрх зүйн харилцаанд эрх эдлэх, үүрэг хүлээх чадварыг хэлдэг. Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болдог. Тухайлбал, дөнгөж төрсөн хүүхэд эд хөрөнгө өвлөх, өмчлөгч байх эрхийг эзэмшиж болдог¹.

Иргэний эрх зүйн чадамж гэдэг нь иргэн өөрийн үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох чадварыг хэлдэг. Иргэний эрх зүйн чадамж нь тухайн иргэний тодорхой үр холбогдол бүхий үйлдэл гүйцэтгэх боломжийг илэрхийлэхийн зэрэгцээ бусад оролцогчид уг эрхэд дүйцсэн үүрэг гүйцэтгэж, зөрчил гаргахгүй байхад чиглэсэн байдагт гол агуулга нь оршино.

Иргэний эрх зүйн чадамжийн төрөл	Хамаарах хүн
Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн	<ul style="list-style-type: none"> - 7 хүртэлх насны этгээд; - Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээд
Иргэний эрх зүйн зарим чадамж	<ul style="list-style-type: none"> - 7-гоос 14 хүртэлх насны этгээд; - 7-гоос 14 хүртэлх насны этгээдийн хийсэн өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг тэдгээрийн нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хийнэ.
Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж	<ul style="list-style-type: none"> - Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд; - Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, харгалзан дэмжигч/-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ. - Насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр дараах эрхээ бие даан хэрэгжүүлж болно: <ol style="list-style-type: none"> 1. өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах; 2. өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх; 3. өөрийн хөдөлмөрийн хөлс, орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах. 4. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно.

¹ Жамбалдорж. О. Монгол Улсын Иргэний эрх зүй. Уб., 2004 он, 93 дахь тал.

Иргэний эрх зүйн бүрэн чадамж	<ul style="list-style-type: none"> - Иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно. - Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно. - Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон шүүхийн шийдвэрийг зохих үндэслэл байвал сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх хүчингүй болгож болно.
-------------------------------	---

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болно.

Хяналтын асуулт:

1. Ял эдэлж буй байдал нь иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах үндэслэл болох уу?
2. Хоригдол иргэний эрх зүйн харилцаанд хэрхэн оролцох вэ?

СЭДЭВ 3. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

Эрүүгийн хууль нь гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулдаг хууль тогтоомжийн дотор тэргүүлэх байр эзэлдэг хууль тогтоомж бөгөөд тус хуулиар гэмт хэрэг, түүнд оногдуулах ял, албадлагын арга хэмжээг тогтоон хуульчилдаг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хууль тус улсын нийт нутаг дэвсгэр дээр үйлчилж тодорхой эрх зүйн үр дагаврыг төрүүлдэг нийгэмд аюултай, гэмт буруутай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох талаар дээд хүчин чадалтай хэм хэмжээний бүрдэл юм.

Эрүүгийн хууль нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал зэрэг иргэн, төр, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжийн амин чухал эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл тухайн эрх ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд гэмт явдалтай хийх тэмцлийг хэрэгжүүлдгээрээ онцлог юм. Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг

үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” гэж заасан нь энэхүү агуулгыг шууд илэрхийлж буй хэрэг юм.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн нэгдүгээр зүйлд зааснаар хууль ёсны зарчим, шударга ёсны зарчим, гэм буруугийн зарчмыг тус тус хуульчилсан нь хуулийн зорилгыг хангах, нэг мөр хэрэглэх, гэмт хэргийг зүйлчлэх, ялыг тохируулж оногдуулахад чухал ач холбогдолтой² гэжээ. Өөрөөр хэлбэл хэдий гэмт хэрэг үйлдсэн ч гэсэн хүлээлгэх хариуцлагыг зөвхөн эрүүгийн хуульд зааснаар оногдуулах бөгөөд төсөөтэй хэрэглэхгүй байх, үйлдсэн гэмт хэрэг, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх, ялгаварлан гадуурхахгүй байх, зөвхөн өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх зэрэг гол үндэслэл, зүй ёсыг баримтална гэж үзэж болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 29 бүлэг гэмт хэргийн ялын дээд хэмжээг харахад 6 бүлэг гэмт хэрэгт бүх насаар хорих, 2 бүлэг гэмт хэрэгт 20 жил 6 бүлэг гэмт хэрэгт 12 жилийн хорих, 6 бүлэг гэмт хэрэгт 8 жилийн хорих ял шийтгэхээр тогтолцоонд оруулан системчлэн хуульчилж, гэмт хэрэг бүрийн ангиллыг харгалзан оногдуулах ялын төрөл, хэмжээг тогтоосон байна.

Гэмт хэргийн тухай ойлголт:

Гэмт хэрэг гэдэг нь эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлдэг.

Гэмт хэргийн шинж	Илрэх хэлбэр
Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан байх	Улсын Их Хурлаас батлан гаргасан, хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн тусгай ангид тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тооцон хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шинжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй.
Гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсан байх	Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд үр дагаврыг шууд учирсан байхыг ойлгоно.

² Гантөмөр, Г., Гантулга, С нар. Эрүүгийн эрх зүй: ерөнхий анги “сурах бичиг”. –Уб., 2020. 31 дэх тал.

<p>Гэмт хэргийг гэм буруутайгаар үйлдсэн байх</p>	<p>Гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна. Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно.</p> <p>Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан бол болгоомжгүй гэмт хэрэгт тооцно.</p>
---	---

Гэмт хэргийг хүнд ба хөнгөн гэж ангилах ба хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд, хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн хохирол, хор уршиг:

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцох ба гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.

Харин "ноцтой хохирол, хор уршиг" гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно. Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршигийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршигийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг мөнгөн дүнгээр тооцож, дараах байдлаар тогтооно.

Хохирлын төрөл	Хэмжээ
Их хэмжээний хохирол	Тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;
Үлэмж хэмжээний хохирол	Арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;
Бага хэмжээний хохирол	Гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг.

Нэг нэгж нь 1000 төгрөгтэй тэнцүү байхаар хуульчилсан байдаг.

Эрүүгийн хариуцлага:

Эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэх ба гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн

улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд зорилго нь оршино.

Ялын төрөл	Хэрэгжүүлэх арга зам
Торгох ял	Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.
Нийтэд тустай ажил хийлгэх ял	Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос дөрвөн зуун наян цагаар тогтооно. Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.
Зорчих эрхийг хязгаарлах ял	Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ. Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.
Хорих ял	Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно. Хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ.

<p>Эрх хасах ял</p>	<p>Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл, эсхүл нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хориглохыг эрх хасах ял гэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно. Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно.</p>
---------------------	---

Гэмт хэрэг үйлдсэн хүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан шүүх ял оногдуулахгүйгээр шийдвэрлэсэн бол эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах үүднээс тодорхой эрхийн хязгаарлалт тогтоож, албадлага хэрэглэдэг. Албадлагын арга хэмжээний мөн чанар нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн хүнд ял шийтгэлийг гарцаагүй байх, нөгөө талаас энэрэнгүй ёсны зарчимтай холбогддог. Иймд дэлхийн ихэнх улс Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн ялаас гадна албадлагын арга хэмжээг түгээмэл хэрэглэж байна.

<p>Албадлагын арга хэмжээний төрөл</p>	<p>Хэрэгжүүлэх арга зам</p>
<p>Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ</p>	<p>Шүүх дараах үүргийг хүлээлгэнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах; - Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах; - Тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх; - Сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх; - Оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх. <p>Шүүх дараах хязгаарлалтыг тогтооно:</p> <ul style="list-style-type: none"> - Тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах; - Галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох; - Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох; - Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох.
<p>Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ</p>	<p>Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана.</p>

<p>Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.</p>	<p>Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.</p> <p>Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.</p>
--	---

Кейс: Дугаар хорих ангид ял эдэлж буй Төмөр овогтой хоригдол Насанбат нь Эрүүгийн хуулийн 17.1-2.1 дэх хэсэгт зааснаар 5 жилийн хорих ялаар шийтгэгдсэн ба ялынхаа 50 хувийг буюу биеэр 1 жил 11 сар 20 өдөр, шагналын 130 хоног, нийт 2 жил 6 сарын хорих ялыг эдэлсэн байна. Хоригдол Т.Насанбат хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоолгох тухай хүсэлт гаргасан боловч хорих ангийн арга зүйн зөвлөл гэм хорын төлбөрөө бүрэн барагдуулаагүй гэх үндэслэлээр түүний хүсэлтийг Прокурорын байгууллагад хүргүүлэхээс татгалзсан байна. Хорих ангийн арга зүйн зөвлөлийн шийдвэр үндэслэлтэй юу?

Шийдэл: Хорих ангийн арга зүйн зөвлөлийн шийдвэр үндэслэлтэй байна. Учир нь Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно” гэж заасан тул хоригдол Т.Насанбат бусдад учруулсан гэм хорын төлбөрөө бүрэн барагдуулсан тохиолдолд хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоох эрх зүйн үндэс бүрдэнэ.

СЭДЭВ 4. ЗӨРЧЛИЙН ХУУЛЬ

Зөрчлийн тухай хуулийн зорилгыг “хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөрчил хаана гарсныг үл харгалзан зөрчлийн хуулийн дагуу явагдана. Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн ба энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ” гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг санаатай болон болгоомжгүй байдлаар зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил болно.

Захиргааны хэм хэмжээний акт гэж захиргааны үйл ажиллагааны нэгэн эрх зүйн хэлбэр бөгөөд хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх шинжтэй шийдвэрийг ойлгоно.

Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй бөгөөд тухайн зөрчлийг шалган тогтоох, зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах эсэхийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.

Зөрчлийн тухай ойлголт:

Зөрчил гэдэг нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлдэг. Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно гэж заасан бол Эрх зүйн зөрчил гэдгийг “эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэмд хор уршиг бүхий хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэсэн, эрх зүйн хариуцлага хүлээх үндэслэлтэй, субъектийн гэм буруутай үйлдэл, эс үйлдэл” гэж тодорхойлжээ.

Зөрчил гэх ойлголт нь өргөн цар хүрээг хамрах бөгөөд үүнээс дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг;
- Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг;
- Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг;
- Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг;
- Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг;
- Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, даатгалын журмын эсрэг;
- Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг;
- хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг;
- Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг;
- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг;
- Монгол Улсын хилийн аюулгүй байдлын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад зорчих журмын эсрэг зөрчил гэж ангилдаг.

Зөрчил үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн бол шийтгэл оногдуулахгүй бөгөөд үүнд:

- 10-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл сануулах, эсхүл баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн;
- 500-10000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;
- 10000-20000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;
- Торгох шийтгэлийг хохирол, хор уршгийн тодорхой хувиар тооцон оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш 3 жил өнгөрсөн;
- Өрсөлдөөний тухай хууль зөрчих зөрчил үйлдсэнээс хойш 3 жил өнгөрсөн;
- Татварын тухай хууль зөрчих зөрчил үйлдсэнээс хойш 4 жил өнгөрсөн;
- Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчлийг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн.

- Зөрчлийг хуулийн этгээд үйлдсэн бол торгох шийтгэлийн хэмжээг 10 дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох бөгөөд зөвхөн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан бол торгох шийтгэлийн хэмжээг 10 дахин багасгаж торгох шийтгэлийн хэмжээтэй дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.
- Хэд хэдэн зөрчил үйлдсэн бол зөрчил бүрд хөөн хэлэлцэх хугацааг тус тусад нь тоолно.
- Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно.
- Хэрэв хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй ба хуулийн дагуу шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, хэрэг бүртгэлийн хэрэг хаах, нээхээс татгалзах тухай шийдвэр, шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно.

Зөрчлийн шийтгэл:

Шийтгэлийн зорилго нь зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршиг, зөрчлийг арилгуулахад чиглэгддэг ба зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулдаг.

Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх бөгөөд 14-16 хүртэл насны хүн мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, олон нийтийн газарт, эсхүл орон байранд хэрүүл маргаан үүсгэж, бусдыг өдөөн хатгаж, бусдын амгалан тайван байдал алдагдуулж, олон нийтийг үл хүндэтгэж, үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүлаж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, шатамхай бодис, пиротехникийн эдлэхүүнийг бүртгэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах журам зөрчсөн зөрчил үйлдсэн бол шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх ба шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь шийтгэлийн зорилгыг хангах боломжгүй бол шүүгч

зөрчил үйлдэгдэх үед тухайн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэдэг.

Зөрчлийн шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл:

Шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл	Хэрэгжүүлэх арга зам
Шийтгэл	
Торгох шийтгэл	<p>Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.</p> <p>Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна. Нэг торгуулийн нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.</p> <p>Торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.</p>
Баривчлах шийтгэл	<p>Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ.</p> <p>Шүүх баривчлах шийтгэлийг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй.</p> <p>Баривчлах шийтгэл оногдуулахгүй тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.</p>

<p>Эрх хасах шийтгэл</p>	<p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ.</p> <p>Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно.</p> <p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.</p>
<p>Албадлагын арга хэмжээ</p>	
<p>Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх</p>	<p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана.</p>
<p>Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах</p>	<p>Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг хураана. Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.</p>
<p>Хохирол, нөхөн төлбөр гаргуулах</p>	<p>Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p>
<p>Албадан эмчлэх</p>	<p>Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно.</p>
<p>Албадан сургалт</p>	<p>Шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.</p>

Кейс: Нэгэн компанийн захиралд шаардлага хангахгүй үйл ажиллагаа явуулсных нь төлөө өөрт нь эрх хасах шийтгэл ногдуулж, аж ахуйн нэгжийг нь торгосон байна. Захирал шийтгэл нь давхардсан, хууль бус гэж үзэн маргаан үүсгэсэн байна.

Шийдэл: Зөрчлийн тухай хуулийн 2.1-д зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг үйлдсэн хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан тул шийдвэр хууль зүйн үндэстэй байна.

СЭДЭВ 5. ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

“Нийгмийн бүхий л төрлийн харилцаанд, тэр дундаа гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байна. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн, эрэгтэй эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд заасан байдаг учраас энэхүү эрхийг баталгаажуулсан Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулиуд үйлчилж байдаг.

Гэр бүлийн тухай хууль нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцөлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт *“Гэр бүл гэж” гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно...*” гэж заасан.

“Гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насан хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг ойлгоно.

Гэрлэгчдийн эрх, үүрэг:

- Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.
- Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах тэгш эрхтэй;
- Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээнэ.

Гэр бүлийн гишүүдийн дунд эрх, үүрэгтэй холбоотой маргаан гарвал нэхэмжлэлийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг:

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д “үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэж заасан. Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;
- Хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх;
- Хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох
- Хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах;
- Эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхдэдээ хэрцгий хандах, эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглоно;
- Эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэдгээрийн үүрэг хэвээр үлдэнэ;
- Эцэг, эх үүргээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг шүүх тогтооно;
- Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно;
- Хүүхдийн эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан нь үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй;
- Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа нөхцөлд үүргээ хэрэгжүүлж байгаад нь харьяалах сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага хяналт тавина;
- Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хохироосон эцэг, эх хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээж, эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан үйлдлийг хийж, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүхээр хасуулсан бол хүүхдээ бага наснаас нь өсгөн хүмүүжүүлээгүй нь тогтоогдсон бол тухайн хүүхдийн эцэг, эхийн хувьд эдлэх эрхээ алдана.

Гэр бүлийн гишүүдийг асран хамгаалах харгалзан дэмжих үүрэг:

Асран хамгаалах, харгалзан дэмжих гэдэгт насны болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоож, эрхийг нь хамгаалж байгаа үйл ажиллагааг ойлгоно.

Асран хамгаалалтад:

- Бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин хүүхэд;
- Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд;
- Эцэг, эх хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газар ял эдэлж байгаа зэрэг шалтгааны улмаас хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд. /Хүүхдийн ээж, аав хоёул 6 сараас дээш хугацаагаар эмнэлэгт эмчлүүлэх тухай эмч нарын зөвлөгөөний шийдвэр гарсан байвал удаан хугацаагаар эмчлүүлж байгаа гэж үздэг байна/
- Сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн зэрэг багтана.

Харгалзан дэмжлэгт:

- Насанд хүрээгүй /14-18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд;
- Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд;
- Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд;
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн;
- Эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн. /Гэр бүлийн тухай хуулийн 63 дугаар зүйл/

Асрам хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг:

- Асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хоол, хүнс, орон сууцаар хангах, асран сувилах;
- Асрамж, дэмжлэгтээ байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- Асрамж, дэмжлэгтээ байгаа хүний мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас, бусад баримт бичгийг банканд хадгалуулах;
- Асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх эд хөрөнгө, мал, банканд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоохдоо тухайн сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах;
- Хүлээсэн үүргийнхээ талаар тухайн сум, дүүргийн Засаг даргад жил бүр тайлагнах зэрэг үүрэгтэй байна.

Кейс: Иргэн Б, 3 нар гэр бүл болж хамтран амьдарч эхлэв. Удалгүй 3-гийн дагавар хүүхэд Б, 3 нартай хамт амьдрахаар болсон боловч Б энэ бол өмнөх амьдрал одоо шинэ амьдрал тул хүүхэдтэй чинь хамт амьдрахгүй гэж татгалзжээ.

Шийдэл: Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д зааснаар “Гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садны хүнийг хэлнэ.

- Хүүхэд төрснөөр эцэг, эх, хүүхдийн хооронд
- Хүүхдийг үрчлэн авснаар эцэг, эх, хүүхдийн хооронд
- Дагавар хүүхэд хойд эцэг, хойд эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн хооронд харилцаа үүсэх талаар хуульчилсан тул иргэн Б үйлдэл хууль бус үйлдэл болно.

СЭДЭВ 6. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан

үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр давамгайлж бие болон сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учруулж, санаатайгаар доромжлон хүч хэрэглэж байгаа үйлдэхийг хэлнэ. Мөн хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоон, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм.

Гэр бүл дэх хүчирхийлэл нь нэг удаагийн санаандгүй үйлдэл бус дахин давтагдах, даамжрах шинж чанартай үйлдэл болохын хувьд нийгмийн бусад хэлбэрийн хүчирхийллээс ялгагддаг.

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн талаар зааж өгсөн. Үүнд:

1. Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
2. Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүүг ойлгоно.
3. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна³.

Гэр бүлийн хүчирхийллийг хүмүүс ихэвчлэн гэр бүл дотор эхнэр, нөхрийн хооронд үйлдэгддэг гэж ойлгодог ч бодит байдалд өргөн хүрээг хамардаг. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчтой нэг гэрт амьдардаг эсэхээс үл хамааран эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүнээс гадна хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн болон тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг ойр дотны харилцаатай хүмүүсийн хооронд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүний хооронд үйлдэгдсэн хүчирхийлэл ялгаагүй гэр бүлийн хүчирхийлэлд тооцогдоно .

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг хяналтдаа байлгахын тулд янз бүрийн арга, тактик ашигладаг. Үүнээс шалтгаалан гэр бүлийн хүчирхийлэл нь нийтлэг дараах хэлбэрүүдтэй. Үүнд:

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 3 дугаар зүйл

- Бие махбодын хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Эдийн засгийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл

Бие махбодын хүчирхийлэл гэж юу вэ?

Бие махбодын хүчирхийлэл гэж гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусаддаа хяналтаа тогтоон, хамааралд оруулах зорилгоор биед нь халдан өвдөлт мэдрүүлж, бэртэл, гэмтэл учруулах болон учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Бие махбодын хүчирхийллийн үр дагавар нүдэнд шууд харагдахуйц байдаг тул хүчирхийллийн энэ төрлийг хүн бүр мэддэг. Гэхдээ энэ нь хамгийн их үйлдэгддэг хүчирхийллийн төрөл биш юм.

Сэтгэл санааны хүчирхийлэл гэж юу вэ?

Гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусдынхаа хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, доромжлох, дорд үзэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх, нэр төр, алдар хүндийг нь гутаах, гүтгэх, мөрдөн мөшгих, ах дүү, төрөл төрөгсөд, хамт олноос нь тусгаарлах, бусадтай харилцахыг хязгаарлах, эд хөрөнгөө сүйтгэх, гэрийн тэжээмэл амьтанд уур хилэнгээ гаргах болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь хамгийн түгээмэл үйлдэгддэг ч хүмүүс хүчирхийлэл гэж үзэх нь бага. Хохирогч ч бас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байна гэж анзаарч таньдаггүй тул байнга давтагдаж байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрүүдтэй хавсардаг, нүдэнд илт харагдаж мэдрэгдэхгүй тул үр дагавар, хор уршгийг хэмжих, нотлоход төвөгтэй. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг дуулгавартай болгож, хамааралдаа оруулахын тулд айдас, түгшүүрт оруулж, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нь үгүй хийдэг.

Эдийн засгийн хүчирхийлэл гэж юу вэ?

Гэр бүлийн гишүүн нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарлахыг хэлнэ. Санхүүгийн нөөцийг хяналтдаа байлгах зорилгоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсан аливаа үйлдэл, зан үйл хамаарна.

Бэлгийн хүчирхийлэл гэж юу вэ?

Гэр бүлийн гишүүн, сэтгэл зүйн болон ураг төрлийн хамааралтай хүний эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Бэлгийн сэдэлтэй үг хэллэг, онигоо ярих, зураг, кино, дүрс үзүүлэх, үнсэх, илж таалах зэргээр биед нь зөвшөөрөлгүй хүрэх, хүсээгүй байхад бэлгийн харьцаанд орохыг албадах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, зэвсэг, эсхүл өөр бусад зүйлсийг хэрэглэн бэлгийн шинжтэй үйлдэлд албадах, хүчиндэх болон хүчиндэхээр завдах үйлдлүүд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь өргөн хүрээтэй ойлголт ба дараах чиглэлүүдийг өөртөө багтаадаг:

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
- Илрүүлэх, таслан зогсоох;
- Хохирогчийг хамгаалах;
- Хохирогч, гэр бүлийн гишүүдэд үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- Хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох, зан үйлд нөлөөлөх.

Тэгвэл гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хохирогчид дараах үр дагавар үүсдэг гэж үздэг байна. Үүнд:

- сэтгэл санааны хямралаас үүдэлтэй айдас, түгшүүр, сэтгэл гутралд орох;
- биеийн эрүүл мэндийн өвчлөл нэмэгдэх, сэтгэцийн зан үйлийн өөрчлөлд орох;
- амьдралын хэв маяг алдагдах;
- хорт зуршилд автах буюу архи, согтууруулах ундаа, мансууруулах бодист донтох;
- гэр бүлийн бүрэн бүтэн байдал алдагдах буюу салалтад өртөж, хүүхэд өнчрөх;
- ганцаардах буюу амиа хорлох эрсдэл нэмэгдэх,
- хохирогч өөрөө хүчирхийлэл үйлдэгч болох;
- хүүхэд гэрээсээ дайжих, гадуур тэнэх, аюулгүй байдал алдагдах
- хүчирхийллийг харж, сонсож өссөн хүүхэд сэтгэл зүйн хувьд их зовж шаналдаг бөгөөд эрүүл мэнд, сурлагын чанар, хүмүүжил буурах зэрэг үр дагавар үүсдэг байна.

Харин энэхүү гэмт хэргийн улмаас хувь хүнд шууд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс гадна цаашлаад нийгэмд сөрөг үр дагаврыг авч ирдэг гэж үздэг. Яагаад гэвэл гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүдийн хооронд гардаг хувийн шинжтэй харилцаа мэт боловч нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хор уршиг өндөр байдаг тул нийгмийн асуудал гэж авч үзэх үндэслэлтэй юм.

Учир нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг, зөрчил өсөх, гэр бүл салалт нэмэгдэх, хүүхэд өнчрөх, өрх толгойлсон эмэгтэйчүүд олшрох, ядуурал, хараа хяналтгүй хүүхэд, өндөр настнууд нэмэгдэх зэрэг байдлаар олон, олон сөрөг үр дагаврыг араасаа дагуулсаар байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах эрүүгийн хариуцлага.



Кейс: Бат, Цэцэгээ нар хэсэг зуур гэр бүлийн харилцаатай байжээ. Бат хэдийгээр салсан хэдий ч үргэлж гэр бүлийн шинжтэй хэрүүл маргаан хийдэг байсныг Цэцэгээ цагдаагийн байгууллагад хандсан байна.

Шийдэл: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 3.2-д “энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна” гэж заасан тул гэр бүлийн хүчирхийлэл гэж үзнэ.

СЭДЭВ 7. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын тунхаглал, Ерөнхий Ассамблейгаас 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тунхаглалын зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэж тодорхойлсон байдаг.

Өөрөөр хэлбэл хүүхэд гэж хүний төрснөөсөө эхлэн бие даах насанд хүрэх хүртэлх биологийн болон сэтгэл зүйн насны тодотгол юм. Зарим улсад эхийн хэвлийд бойжиж буй ургийг ч хүүхэд хэмээн үзэхээс гадна хэдэн насанд хүүхэд насны дуусвар болохыг ч ялгаатайгаар ойлгодог байна.

Ингэхдээ хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатайг гэр бүл, түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстойг ойлгож, аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөж бойжих нь хүүхдийн бүрэн, өв тэгш хөгжлийг хангах болохыг хүлээн зөвшөөрч хүүхдийн эрхийг олон улсад хамгаалдаг байна.

Монгол Улсын хувьд хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг хангахад чиглэгдсэн “Хүүхдийн эрхийн тухай” хуулийг 2016 онд УИХ-аас батлан гаргасан бөгөөд хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж дараах эрхүүдийг тэгш хангах талаар баталгаажуулсан. Үүнд:



Мөн хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлан, хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангахад чиглэгдсэн зарчмыг баримтлан ажиллаж, амьдрах ёстойг хуульчилж өгсөн байна.

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн тухайд хүүхэд төрмөгцөө бүхий л амьдралынхаа туршид дуудах, дурсах нэрээ авах ба, Монгол Улсын харьяат байх эрхтэй бөгөөд хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг хууль, олон улсын гэрээгээр зохицуулах талаар тусгаж дараах эрхийг нарийвчлан зааж өгсөн байна. Үүнд:

- Эрүүл өсөж бойжих;
- Аюулгүй орчинд амьдрах;
- Аливаа хүчирхийллээс ангид байх;
- Эцэг эхтэйгээ хамт амьдрах;
- Гэр бүлийн анхаарал халамжид байх;
- Эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодлоо илэрхийлэх, эцэг эхтэйгээ байнгын харилцаатай байх;
- Төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах;
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух;
- Эх орондоо амьдрах эрхийг хуулиар олгож өгсөн.

Хөгжих эрхийн тухайд хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үздэг байна. Мөн хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр дараах эрхийг эдлэхээр хуульчилсан. Үүнд:

- Ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших;
- Төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;
- Оюун ухаан, авьяас билиг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах
- Шашин шүтэх, эс шүтэх;

- Чөлөөтэй бодож сэтгэх;
- Өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
- Нас сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээлэл хайх, хүлээн авах;
- Гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх зэргийг дурдаж болно.

Хамгаалуулах эрхийн тухайд энэхүү зөрчигдсэн эрхтэй холбогдсон харилцааг "Хүүхэд хамгааллын тухай" хуулиар зохицуулах бөгөөд нийгмийн бүх орчинд дараах эрхийн хүрээнд хамгаалагддаг байна. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчил, аливаа хүчирхийллээс;
- Бие махбодын шийтгэл эдлэхээс;
- Сэтгэл санааны дарамтаас;
- Үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс;
- Өөрийн нэр төрөөс;
- Хувийн орон зайгаас;
- Гэр бүлийн амьдралаас;
- Хувийн мэдээлэл болон орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах эрхтэй байна.

Мөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй гэж заасан байдаг.

Хэрэв хүүхдийн эрх зөрчигдсэн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх боломжтойг дурдах нь зүйтэй юм.

Нийгмийн амьдралд оролцох эрхийн талаар дурдахаас өмнө нийгмийн тухай тайлбарлах нь зүйтэй юм. Нийгэм бол хүмүүс хоорондын харилцаа, явцуу утгаараа нийгэм нь байнгын нутаг дэвсгэртэй, улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар тогтнолтой, бие даасан соёлтой, нийгмийг бүрдүүлэгч олон түмэн нь сэтгэл зүйн хувьд нэгдмэл шинжтэй байх хүмүүсийн том нийтлэг юм. Тэгвэл энэхүү нэгдэлд орохын тулд хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх зэрэг ялгамжтай байдлаар зааж өгсөн. Учир нь хүүхэд нийгмийн амьдралд оролцох явцад шүүлтүүргүй, замбараагүй мэдээлэлд хууртах, бие, сэтгэхүүд сөрөг нөлөөлөл үзүүлэх, сурлага, хүмүүжлийн доголдолд орох, нийгмийн буруу тогтолцооны золиос болох магадлалтай тул анхаарах шаардлагатай байдаг.

Хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргаж үнэлэлт өгөхөд оролцох, өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүнийхээ үр шимийг хүртэх, хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөж авах, өөрийн нас, онцлогт тохирсон ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй талаар хуульчилсан байдаг.

Тэгвэл гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрхийг хангах, хүүхдээ ухаалаг, төлөв, даруу, энэрэнгүй сэтгэлтэй, зоригтой, үнэнч шударга болгон хүмүүжүүлэхийн тулд тэдний оюун сэтгэхүйн онцлогийг сайн мэдэх хэрэгтэй байдаг.

Хүүхдүүд хоорондоо ижилхэн юм шиг боловч үнэндээ тэдний хүлээн авах чадвар, сэтгэхүйн үйлдлүүд сэтгэл зүйн онцлог зэрэг ялгаатай байдлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч бүр соргоогоор харах учиртай.

Яагаад гэвэл хүүхэд бүрийн хүлээн авах чадвар, өөрийн мэдрэмжээ илэрхийлэх байдал нь ч харилцан адилгүй гэсэн үг юм.

Учир нь гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, хэрүүл маргаантай орчин гэх мэт хүүхдийн өсөж буй орчин хүүхдийн сэтгэл зүй, эрхээ эдлэхэд хүртэл харилцан адилгүй байдлаар нөлөөлдөг гэж үздэг. Иймд эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүүхдийг бидний үргэлжлэл хэмээн бодож өчигдөр хүссэн залбирал, өнөөдөр авсан бэлэг, өтлөхөд түших таяг, буцахад үдэх бурхан минь хэмээн үзэж дор дурдсан үүрэг хүлээхийг зааж өгсөн байна. Үүнд:

- Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчин бүрдүүлэх;
- Хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;
- Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;
- Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;
- Хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;
- Хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;
- Хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;
- Хүүхдийг хөгжиж, төлөвшихөд нь дэмжин туслах;

- Хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;
- Хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах зэргийг дурдаж болно.

Гэр бүл дэх хүүхэд хамгаалал:

Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авах учиртай. Нөгөөтээгүүр хүүхэд гэр бүлийн орчиндоо бусдыг ойлгох, хайрлан хүндлэх, гэр цэвэрлэх зэрэг наад захын ажилд туслах, ах, эгч, дүү нартаа зөв үлгэр дуурайлал үзүүлэх, үнэнч шударга байх зэрэг үүргийг биелүүлэх ёстой.

Мөн хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, өргөдөл, гомдол, шаардлага, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэх байдлаар хамгаалдаг байна.

Хүүхдийн эрхийг хангах тогтолцоо:

НҮБ-аас гаргасан хүүхдийн эрхийн тухай конвенц, үндэсний хууль тогтоомж болон тэр дундаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд тус тус заасанчлан Монгол Улсын Их Хурал хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн болон орон нутгийн бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжид хяналт тавих, хөтөлбөр үйл ажиллагааны санхүүжүүлэх төсөв батлах замаар хүүхдийн эрхийг хангадаг бол засгийн газрын түвшинд хүүхдийг хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалах талаар төлөвлөгөө боловсруулан батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих зохих харилцааг зохицуулсан журам, зааврыг боловсруулах зэрэг гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүүхдийн эрхийг хангах ажлыг яам, агентлагаараа дамжуулан хийж хэрэгжүүлдэг байна.

Харин хүүхдийн эрхийг хангах талаарх салбар дундын үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд,

орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус зохицуулахад тэргүүлэх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх,
- Хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх
- Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт хийх, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах,
- Хүүхдэд зориулсан барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, зориулалтын дагуу ашиглуулах
- Хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ, сургалт, хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг дэмжих, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий Хүүхдийн төлөө сан байгуулах зэрэг болно.

Хүүхдийн эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага:

Эрүүгийн хуульд зааснаар хүүхдийн эрхийг зөрчиж гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдаг. Тэгвэл Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог байна.

Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрддэг бөгөөд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах гэсэн төрөлтэй байдаг.

- Хүнийг алах гэмт хэргийг хүүхдийн эсрэг хийсэн бол 12-20 жил хүртэл, эсхүл бүх насаар нь хорих;
- Эх нь сэтгэл санааны гүнзгий хямралтай байх үедээ нярай хүүхдээ алсан бол 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих;
- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл гэж үзэж 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих

- Хүн худалдаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял хорих;
- Хүн барьцаалах гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих;
- Хүн хүчээр алга болгох гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол 2-8 жил хүртэл хугацаагаар хорих;
- Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол 2700 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих;
- Хүүхдийг санаатайгаар сольсон бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих;
- Төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан бол 10000-40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2-8 жил хүртэл хугацаагаар хорих;
- Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэсэн бол 450-1350 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах;
- Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол 5400-27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих;
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял, 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэдэг эрх зүйн зохицуулалттай байна.

Кейс: Иргэн Цэцэгээ, Ганбат нар хуулийн дагуу гэрлэлтээ цуцлуулсан ба 12 настай хүүхэд нь Цэцэгээ дээр байв. Хүүхдийг сургуулиас гадуур дугуйланд хамруулах төлбөрийн асуудал дээр Ганбат: би хүүхдийн тэтгэлгээ төлдөг тул дугуйлангийн мөнгийг өгөх шаардлагагүй гэжээ.

Шийдэл: Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10.1-д эцэг, эх хүүхдийн эрхийг хангахад тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан тул Ганбат үүрэг хүлээнэ.

СЭДЭВ 8. СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэхэд оршино.

Уг хуульд зааснаар дараах газарт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно:

1. Төрийн байгууллагын эзэмшлийн болон үйл ажиллагаа явуулж байгаа албан байр, барилга байгууламж, газар, хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар, соёл, урлагийн газар, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад байгаа бүх төрлийн барилга байгууламж, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байр;
2. Бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэлд, агаарын хөлөг болон зорчигч тээврийн галт тэрэгний зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт;
3. Шатахуун түгээх газар, шашны байгууллагын байр болон нийтийн эдэлбэр газарт байрлаж байгаа авто тээврийн хэрэгсэл дотор;
4. Галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт;
5. Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь олон нийтийг хамарсан ёслолын арга хэмжээ, урлагийн тоглолт, үзэсгэлэн худалдаа, олон улсын чанартай тэмцээн, уралдаан зохион байгуулах, түүнийг дамжуулан нэвтрүүлэх газарт 18 хүртэлх хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаагаар үйлчилж болохоос бусад олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, спортын арга хэмжээ, тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж байгаа газарт;

6. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэйгөөс бусад этгээдийн ажлын байрны дотоод орчинд;
7. Барилгын батлагдсан зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж, тохижуулснаас бусад орон сууц, түүний өргөтгөл, орц, хонгил, суурийн давхарт 18-аас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаагаар үйлчлэх;
8. Олон нийтийн газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд дараах зүйлийг хориглоно:

1. 21 нас хүрээгүй, эсхүл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
2. Стандарт, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй, эсхүл баталгаажилтгүй, эсхүл савлагаа нь энэ хуулийн 12.7-д заасан шаардлагад нийцээгүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
3. Онцгой албан татварын тэмдэггүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
4. Согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд цахим орчин, холбооны хэрэгсэл, өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хаягаар хүргэх;
5. Стандарт, техникийн шаардлагыг хангаагүй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
6. Согтууруулах ундааг гар дээрээс, эсхүл согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, түдгэлзүүлсэн үед худалдах, түүгээр үйлчлэхийг тус тус хориглодог байна.

Хяналтын асуулт:

1. Согтууруулах ундааны зүйлийг гэр орондоо үр хүүхдийнхээ дэргэд хэрэглэж болох уу?
2. Согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шүүхээс хэргийг хэрхэн авч үздэг вэ?

СЭДЭВ 9. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн зорилт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.

Хуульд эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа, хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийн олборлолт, ургамлын тархцад хяналт тавих;
- Гаалийн болон хил хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох;
- Цагдаа, тагнуул, хил хяналтын болон холбогдох бусад байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй байна.

Харин энэхүү байгууллагуудын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байхаар хуульчилж өгсөн онцлогтой.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн болон орон нутгийн байгууллага, түүнчлэн эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй байдаг.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар эрх бүхий байгууллагаас бэлтгэж, хянасан сурталчилгааны материалыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүй түгээх зэрэг үүрэг

хүлээхээр хуульчилсан.

Энэхүү бодисын хор хөнөөлтэй хийх тэмцэлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагад зайлшгүй шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс гаргах, тэдгээрийн хууль бус эргэлтийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор амьтан сургах, хяналтын болон лабораторийн шинжилгээний техник хэрэгслээр хангахад төрөөс зохих дэмжлэг хөнгөлөлт үзүүлэх зэргийг дурдаж болно.

Хүн сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсний дараа бие организмд дахин хэрэглэх зуршил үүсэх, бодисыг хүсэж буй мэт мэдээллийг байнга тархин дамжуулах, сэтгэл зүйн хувьд таатай мэт гаж мэдрэмж бий болгодог онцлогтой. Өөрөөр хэлбэл мансууруулах бодис хэрэглэх нь мансуурах, донтох, сэтгэцийн гаж хөөрөлд орох, гуньж гутрах зэргээр сэтгэц мэдрэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж цаашлаад хүний бие мансууруулах бодисгүйгээр хэвийн байж чадахаа больж уг бодис л байхгүй бол оршин тогтнох боломжгүй мэт сэтгэгдэл төрөн бие махбод мансууруулах бодисыг нэхэж, үгүйлэх байдалтай болсноор оюун ухаан доройтож донтох эмгэгт өртдөг гэсэн үг юм.



Оюун ухаан доройтож донтох: Донтох гэдэг нь дон буюу ад, хий юм биед нөхцөх, муу шинж орох, нөхцөх, хорхойсох гэсэн үгнээс үүсэлтэй. Харин шинжлэх ухаанд үүнийг сэтгэцэд идэвхт бодис хэрэглэх сэтгэцийн ба төрх үйлийн эмгэг гэж албан ёсоор нэрлэдэг байна. Сэтгэц идэвхт бодисын үүсгэж байгаа сэтгэлийн таашаал бүхий

сэтгэцийн өвөрмөц байдлыг мансуурал гэх бөгөөд бодист донтсон хүний уураг тархи, сэтгэцийг мансууруулж бодистоо дасах, үгүйлэх, хэрэглэхгүй бол байж суух газаргүй байдалд хүргэх буюу хараат байдалд оруулдаг байна.



Өөрөөр хэлбэл бүх бие нь янгинан өвдөх тул бодисоо олж хэрэглэхийн тулд юу ч хийхээс буцахгүй араатан мэт болгож гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг гэсэн үг юм. Мансууруулах бодисоос бүрэн хараат болсон хэн нэгэн өөрөө хүсээд энэ хөнөөлт зуршил болсон бодисоос гарах боломжгүй мэт боловч тэвчих,

эрүүлжих нь бас боломжгүй зүйл биш юм. Гэвч энэ асуудлыг ганцаараа шийдэх гэж зүтгэх биш харин эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж авах хэрэгтэй байдаг.

Нүдний болор цайх: Хэдий чинээ их хэрэглэнэ, төдий чинээ нүдний хүүхэн хараа томорч, нүдний болор цайж сохрох аюултай.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нөлөөллөөс үүсэх өвчлөл:

Өсвөр насныхны өсөлт зогсож эрэгтэй хүн суурь өвчлөл нэмэгдэх дархлалыг систем алдагдаж, үрийн шингэн багасах, эмэгтэй хүний дуу бүдүүрч, хөх жижгэрэх шинж тэмдэг илэрдэг бөгөөд хүний наслах хугацаа богиносж 6-8 сар насалсан нь ч тохиолдол байдаг байна.

Мөн арьс олон газар урагдан гэмтэх, эдгэрэлт удаашрах, судас, хурууны арьс, хумс хөхөрч, цайж, өнгө алдан хуурайшдаг байна. Судас хагарах, халуурах, чичрэх явдал гардаг. Тариагаар хийвэл ДОХ, шархлаа болох элэг үрэвсэж В, С гепатит өвчилж цаашлаад хорт хавдар үүсэх тохиолдол элбэл тохиолддог бол уушгины үйл ажиллагааг муутган, багтраа өвчнөөр амархан өвчлөх, уушгины хорт хавдар өвчинд илүү нэрвэгдэг байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай буюу донтсон хүнийг эмчлэх асуудлыг 2018 онд УИХ-аас батлагдсан Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулиар мансуурах донтой хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтын доор захиргааны журмаар албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Учир нь мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулдаг гэсэн ойлголт юм.

Өөрөөр хэлбэл болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өрхийн болон сумын эмч, эсхүл сэтгэц, наркологийн эмч, сум, хорооны нийгмийн ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүн нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтсон хүнийг албадан эмчлүүлэх тухай саналыг цагдаагийн байгууллагын алба хаагч гаргаж болох эрх зүйн зохицуулалтай юм.

Цагдаагийн байгууллага дээрх хүсэлтийг хүлээн авмагц тухайн хүний хувийн баримт бичиг, тодорхойлолтыг бүрдүүлж, албадан эмчлэх үндэслэл бүхий дүгнэлт гаргуулахаар тухайн хүний харьяалагдах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад хандаж гаргуулан

тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах саналыг шүүхэд гарган шийдвэрлүүлдэг байна.

Албадан эмчилгээг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан 3-6 сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд 6 сараас 2 жил хүртэл хугацаатай хийгддэг байна.

Мөн албадан эмчилгээнд хамрагдсан хүн эмчилгээ дууссаны дараа оршин суугаа нутаг дэвсгэртээ байрлах эмнэлгийн сэтгэц, наркологийн эмчид бүртгүүлэн өрхийн, эсхүл сумын эмчийн хяналтад орж, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн дагуу бататгах эмчилгээнд хамрагдах бөгөөд эмч, нийгмийн ажилтан хариуцан бататгах эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд зориулан нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түүний гэр бүл, тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран явуулж болно.

Кейс: Олон нийтийн сүлжээний контент бүтээгч байгууллага мансууруулах эмд ордог бүтээгдэхүүнийг ургадаг газар, байршлын талаар нэвтрүүлэг бэлдэн интернэтээр тараасан тул цагдаагийн байгууллагаас шалгалт явуулахад “энэ бол зүгээр нэвтрүүлэг, бидний эрх гэж” хариу гомдол гаргасан байна.

Шийдэл: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан кино, дуу, дүрс бичлэгт хуурцаг, ном товхимол, хэвлэмэл зургийг нийтэд түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компьютерын сүлжээг ашиглан сурталчлах"-ыг хориглосон тул тухайн байгууллагын гомдол үндэслэлгүй юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БҮЙ ХОРИГДОЛД ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

СЭДЭВ 1. ХҮНИЙ АМЬД ЯВАХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Хүнийг алах гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилдаг хүний амьд явах эрх байна. Энэ эрхийг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйлд: “Хүн бүр амьд явах эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Амьд явах эрх бол хүн бүрийн салшгүй эрх мөн. Энэ эрхийг энэ хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй” гэж тус тус заасан.

Хүнийг алах гэмт хэрэг гэдэг нь хүний амьд явах эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Хүнийг алах гэмт хэргийн халдлагад өртөгч буюу хохирогч нь нас барсан хүн байна. Мөн хүнийг алсан идэвхтэй үйлдэл нь об’ектив тал бөгөөд энэхүү үйлдлийн улмаас хүн нас барсан хохирол учирсан байх бөгөөд хүнийг алсан гэмт үйлдэл, хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байна. Хүнийг алах гэмт хэрэг нь хүн нас барснаар төгсдөг.

Хүн алах гэмт хэрэг нь санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох хүн нас барах хохирлыг хүсэж, хүсээгүй боловч үйлдлээрээ уг хохиролд хүргэсэн гэм буруугийн шууд болон шууд бус санаатай хэлбэртэй байна.



Хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд найман жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх ба дараах хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хүнийг алсан бол оногдуулах ялыг чангаруулж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах гэмт хэргийн тухай

Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах гэмт хэрэг гэдэг нь хүний амьд явах эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр, гэмт хэрэг үйлдэх үедээ санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж халдсан, Эрүүгийн хуулийн 10.2 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Хохирогчийн зүгээс гэмт этгээд, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжилсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсан үедээ хүнийг алах идэвхтэй үйлдэл хийсэн байна. Энэхүү үйлдлийн улмаас хүн нас барсан хохирол учирсан байх бөгөөд хүнийг алсан гэмт үйлдэл, хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байна. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах гэмт хэрэг нь хүн нас барснаар төгсдөг материаллаг шинжтэй гэмт хэрэг юм.

Ойр дотнын хүн гэдэг нь тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садны хүнийг ойлгоно.

Хүч хэрэглэсэн гэдэг нь хохирогч гэмт этгээдийн бие махбодод халдсаныг ойлгоно. Гэмт этгээдийн бие махбодод халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, хоолойг боох зэрэг хэлбэртэй байдаг бол хүч хэрэглэхээр заналхийлсэн гэдэг нь хохирогч гэмт этгээд болон ойр дотнын хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана зэргээр айлган сүрдүүлж, сэтгэл санааны хүчирхийлэлд өртүүлснийг ойлгох юм.

Харин хүндээр доромжилсон гэдэг бол нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг гутаасан үйлдлийг ойлгож болох юм. Тухайлбал, хүнийг сөгдүүлэх, гутлаа долоолгох, нүүр лүү нь бие засах зэрэг хүний мөн чанарыг үгүйсгэн гутаан доромжилсон үйлдэл байж болдог. Энэ нь хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, хөрөнгө чинээ, эрүүл мэнд, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илрэх бол хохирогч гэмт этгээдийн бие махбодыг болон сэтгэл санааны албадлагад оруулсны

улмаас эрхшээлд автаж хүнийг алсан бол эрхшээлд дарамтад оруулсан гэж үзэж болно.

Хохирогчийн зүй бус үйлдэл гэдэгт гэмт этгээд болон түүний ойр дотнын хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүндээр доромжлох, эрхшээл дарамтад байлгахаас бусад хууль бус үйлдлийг ойлгоно. Тухайлбал, эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх, устгах, гэмтээх, хүний төрөлхийн жам ёсны эрхийг хязгаарлах, хориглох, дураараа аашлах, гүтгэх гэх мэт юм.

Санаа сэтгэл цочрон давчдаж хүнийг алах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох хүн нас барах хохирлыг хүсэж, хүсээгүй боловч үйлдлээрээ уг хохиролд хүргэсэн гэм буруугийн шууд болон шууд бус санаатай хэлбэрээр үйлддэг. Мөн өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжилсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас гэмт этгээдийн санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж, хүнийг алах санаа гэнэт, хоромхон зуур төрсөн бөгөөд сэтгэхүйн хувьд хэвийн байдал алдагдсан байдгаараа хүнийг алах гэмт хэргээс ялгагдана.

Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Эрүүгийн хуульд зааснаар өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүнийг алсан бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн хариуцлагыг тодорхойлжээ.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэргийн тухай

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг гэдэг нь хүний амьд явах эрхэд гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 10.6 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилдаг.

Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй, бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь нас хохирсон байна. Энэхүү үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь нас хохирсон байх бөгөөд

хүний амь насыг хохироосон гэмт үйлдэл, эс үйлдэхүй, хохирол хоёрын хооронд шууд болон шууд бус шалтгаант холбоо байна. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг нь хүний амь нас хохирсон хохирол учирснаар төгсдөг материаллаг шинжтэй гэмт хэрэг юм.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгддэг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүний улмаас хүний амь нас хохирох боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хүний амь нас хохирсон, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хүний амь нас хохирсон байдаг.

Тус хэргийг үйлдсэн этгээд нь Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Тухайн хүн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн хэн ч байж болно.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Эрүүгийн хуульд зааснаар болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь насыг хохироосон бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийн улмаас 2 түүнээс олон хүний амь насыг хохироосон бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.

Хяналтын асуулт:

1. Хүнийг алах гэмт хэргийн улмаас нийгэм, гэр бүлд ямар хор уршиг учрах вэ?
2. Хүнийг алах гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй хоригдолд бий болох сөрөг үр дагавар?


СЭДЭВ 2. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ

Хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг:

Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд, гэмт буруугийн санаатай хэлбэрээр буюу хүч хэрэглэн халдаж эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол 10000-40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ гэж заажээ. Харин хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол 5-12 жил хүртэл хорих ял шийтгэхээр хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруугийн санаатай үйлдэл гэж заасан байна.

Хүндрүүлэх нөхцөл байдал гэдэг нь Эрүүгийн хуульд зааснаар хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн зэргийг тогтоож гэмт хэрэгтний ялыг хүндрүүлэх байдлаар шийдвэрлэж буй асуудал юм.

Тэгвэл гэмтлийн "хүнд" зэрэг буюу хүнд хэмжээний хохирол учрахыг хохирогч гэмтэх үед амь нас хохирч болох буюу амь тэнссэн байдалд орсон, удаан хугацааны дараа үхэлд хүргэж болох гэмтэлд орсон байдлыг ойлгодог байна. Нөгөөтээгүүр хохирогчид тухайн гэмт хэргийн улмаас үүссэн гэмтлийн үлдэц, хор нөлөө, уршиг зэрэг нь хөдөлмөрлөх ерөнхий чадварт их хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх ба мэргэжлийн байгууллага шинжээч нь хүнд гэмтлийг дараах шалгуур шинжээр тогтоодог байна. Үүнд:



Энэхүү гэмт хэргийн хор уршгаар хохирогч хөдөлмөрийн чадвараа алдаж өөрийн болон гэр бүлийн гишүүдийг тэжээн тэтгэх боломжгүй болон өрхийн орлого буурах, хүнд гэмтлийн улмаас тогтмол эм, тариа, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх байдлаар гарах зардал нэмэгдэх, ойр дотнын

хүний байнгын хараа хяналт, асаргаа сувилгаанд байх шаардлага зэрэг цаг зарцуулалт нэмэгддэг тул гэр бүлийн гишүүний хэн нэгний сурах, хөдөлмөрлөх боломж алдагдахад зэрэг нөхцөл байдалд хүргэдэг байна.

Энэхүү гэмт хэргийн нөхцөл байдлаас харахад хохирогч дан ганц бие хүн байгаад зогсохгүй бүхэл бүтэн гэр бүл буюу эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх, өндөр настан гэх зэрэг олон хүн буюу нийгмийн тодорхой бүлэг хохирдог гэдгийг дурдах нь зүйтэй.

Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэргийн хувьд хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд гэм буруугийн санаатай хэлбэрээр, гэмт хэрэг үйлдэх үедээ санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж халдсан, Эрүүгийн хуулийн 11.2 дугаар зүйлд "өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол 2700-14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм хэмээн хуульд заажээ.

Энэхүү гэмт хэргийн хувьд хохирогчид учирсан хохирол, үр дагавар нь өмнө дурдсан гэмт хэргийн хохирогчтой ижил нөхцөл байдлыг үүсгэх хэдий боловч гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд эрх, эрх чөлөөгөө хуульд заасан хугацаагаар хасуулах, амьдралдаа гэмт хэрэгтэн гэж дуудуулах хар толботой болон үлдэх, шүүхээс оногдуулсан ялын хугацаанд үр хүүхэд, ойр дотнын хүнээс тусгаарлагдаж өдөр тутмын халамж, анхаарал хандуулах боломж буурах, орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл зүйн хувьд хямрах, айх, ичих, түгшүүр нэмэгдэх байдлаар цочролд өртөх зэрэг эрүүл мэндийн хувьд муудах, хөдөлмөрлөх, сурах, өсөн дэвших боломж зэрэгт хугацаа алдаж байдаг байна.

Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд гэмт буруугийн болгоомжгүй хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 11.3 дугаар зүйлд "хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж 2700-14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг

хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Өөрөөр хэлбэл болгоомжгүй гэм буруугийн хэлбэр нь гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдсэн боловч түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцон өөртөө найдаж үйлдсэн, эсхүл өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй⁴ буюу хайхрамжгүй үйлдэхийг хэлдэг байна.

Жишээлбэл иргэн “Б” өөрийн хашааны чулууг цэвэрлэх явцдаа зарим нэг чулууг хашаа давуулан шидэж байв. Тэрбээр энэхүү үйлдлээ гудамд явсан хүнийг цохин гэмтээж болзошгүй гэдгийг мэдсэн боловч одоохондоо хүн байхгүй хэмээн бодож шидсэн чулуу нь хүн цохиж хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг үйлдсэн байна. Энэхүү үйл явдлаас харахад гэмт хэрэгтэн “Б” би хүн цохиж хүнд гэмтэл учруулахыг хүсээгүй, гэхдээ хүн цохиж хүнд гэмтэл учруулж болзошгүйг мэдэж байсан ч арай хүн онохгүй байх гэж найдаж шидсэн үйлдэл нь гэмт хэрэгтэн болгосон байна.

Хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл санаатай учруулах гэмт хэргийн ойлголт хүлээлгэх хариуцлага:

Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэмт буруутай үйлдэл гэж тодорхойлжээ.

Энэхүү хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд 450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэх эрх зүйн зохицуулалттай. Хүндрүүлэх нөхцөл байдал нь

⁴ Нарангэрэл, С. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Уб., 2021. 59 дэх тал.



СЭДЭВ 3. ХУЛГАЙЛАХ, ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРЭГ

Хулгайлах гэмт хэргийн ойлголт, хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Хулгайлах гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд “бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Хулгайлах гэмт хэргийн үндсэн шинж нь бусдын өмчлөх эрхэд халдаж хууль бусаар, хүч хэрэглэхгүйгээр буюу нууцаар бага хэмжээнээс дээш хохирол учруулж авсан буюу бусдын эд хөрөнгийг захиран зарцуулах боломж бүрдүүлсэн эсхүл захиран зарцуулснаар энэхүү гэмт хэрэг төгсдөг материаллаг шинжтэй гэмт хэргийн төрөл юм. Тэгвэл бага хэмжээний хохирол гэдгийг хуульд гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээний хохирол учирсныг ойлгох эрх зүйн ойлголт юм.

Харин хууль бусаар авсан гэдэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууц, далд аргаар авч, өөртөө захиран зарцуулах боломж бүрдүүлэх, захиран зарцуулсныг ойлгоно.

Хүч хэрэглэхгүйгээр гэж бусдын амь нас, эрүүл мэндийн халдашгүй байдалд ямар нэгэн хохирол учруулж, халдаагүй үйлдсэн үйлдлийг хэлдэг байна.

Хулгайлах гэмт хэргийн нууцаар авсан гэдэг нь бусдын эд хөрөнгийг өмчлөгч болон бусад хүмүүст мэдэгдэлгүйгээр далд аргаар авсныг ойлгодог бол бага насны, өндөр настай, сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй,

согтуурсан, мансуурсан, унтаж байсан, хөгжлийн бэрхшээлтэй /сохор, дүлий/ зэрэг бусад байдлаас шалтгаалан тухайн үед болж байгаа үйл явдлыг мэдрэхгүй, ойлгож мэдэхгүй, илчлэх чадваргүй байдлыг далимдуулан тэдний дэргэд эд хөрөнгийг авсан үйлдлийг бусдын эд хөрөнгийг нууцаар авсантай адилтган үзэж хулгайлан гэмт хэрэг гэж үздэг.

Нөгөөтээгүүр хулгайлах гэмт хэрэг үйлдэх аргыг дээр дурдсан ойлголтоор хуульд заасан учраас объектив талын үндсэн шинжийг илэрхийлж, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлнө гэж үздэг.

Өөрөөр хэлбэл энэ гэмт хэргийн шинж нь хүч хэрэглэхгүйгээр нууцаар үйлдсэн байх гэсэн ойлголт юм. Энэхүү зүйлчлэлд заасан аргаас өөр аргаар буюу хүч хэрэглэх, хүч хэрэглэхгүй заналхийлэх, илээр гэх зэрэг хууль бусаар бусдын эд хөрөнгийг авсан үйлдэл нь хулгайлах гэмт хэрэг бус харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэж зүйлчлэх үндэслэл болдог байна.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлийн шинжийг заасан байдаг.



Дээрх хүндрүүлэх шинжийг дараах байдлаар тайлбарлаж болно⁵. Үүнд:

- хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн гэж бусдын эд хөрөнгийг хууль бусаар авахын тулд эзэмшигч, өмчлөгчийн орон байр, агуулахад түлхүүр тааруулах, багаж хэрэгсэл ашиглах, хаалга, цонх, түгжээг эвдэх, цуургыг сугалах, онгорхой байхад сэм орох, нуугдах зэрэг бусад аргаар нэвтрэн орсныг ойлгоно.

⁵ Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –УБ., 2018. 180-181 дэх тал.

- Түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгайлан хамгаалсан соёлын өвийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсныг ойлгоно.
- Ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлсан гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсан, эсхүл тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсныг ойлгоно.
- Учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн гэж бусдын эд хөрөнгийг хулгайлах үйлдлийг хөнгөвчлөх, түргэтгэх, биеийн хүч нэмэгдүүлэх, хамгаалалт, бэхэлгээг эвдэх, биеэр авч явж чадахгүй эд хөрөнгөд хүрэх, зөөж тээвэрлэхийн тулд зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэнийг ойлгоно. Харин хулгайлах үйлдэл төгссөний дараа хулгайлсан эд хөрөнгийг зөөж тээвэрлэх, хэргийн газраас зайлуулах зэрэгт машин механизм ашигласан нь энэ ойлголтод хамаарахгүй.
- Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглаж үйлдсэнийг ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно.
- Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно. Өөрөөр хэлбэл, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэдэгт бусдын эд хөрөнгийг хулгайлахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан бүх төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хамааруулан ойлгоно. Харин алх, бахь, хөрөө зэрэг биетийг эвдэх, таслах зориулалт бүхий багаж хэрэгслийг хулгайлах гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж гэх бөгөөд тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэж үздэггүй байна. Учир нь тухайн багаж хэрэгслийг зориулалтын дагуу хууль бус хулгайлах үйлдэлдээ ашигласан бөгөөд тусгайлан бүтээж, засаж тохируулаагүй байдаг.

Машин механизм гэдэгт хүн, ачаа тээвэрлэх зориулалттай бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин болон өргөх буулгах, ухах, малтах, түрэх, цоолох, зүсэх зориулалттай машин механизмууд хамаардаг байна.

Дараагийн хүндрүүлэх шинжийг эрүүгийн хуульд тусгахдаа хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж хүндрүүлэхээр зааж дараах байдлаар тайлбарладаг⁶ байна. Үүнд:

- **Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон** гэж хулгайлах гэмт хэрэг, зөрчлийг тогтвортой, гурав ба түүнээс дээш удаа үйлдэж олсон хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж байгаа явдлыг;
- **Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн** гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс дээш хүний тогтвортой нэгдэл үйлдсэнийг ойлгодог байна.

Хулгайлах гэмт хэргийг ялын хувьд сонгох санцтайгаар хуульчилсан байдаг. Энэ нь шүүх гэмт хэрэгтэн бие хүний хууль бус үйлдлийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанар, хохирлын хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн болон гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт буруугаа ухамсарлаж буй байдал зэргийг харгалзан ял оногдуулах өргөн боломжийн нээн өгсөн байна. Энэ нь зарим судлаачдын үзэж буйгаар ялын төрлийн хувьд гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, эерэг нөлөө үзүүлэн өөрчлөх ач холбогдолтой гэж үздэг.

Дээрэмдэх гэмт хэргийн ойлголт, хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Дээрэмдэх гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдаж Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлд зааснаар “бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

⁶ Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –УБ., 2018. 181-182 дахь тал.



• Дээрэмдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хууль бусаар авсан гэмт үйлдлийн улмаас хохирол учирсан байхыг шаардахгүй



• үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм

Өөрөөр хэлбэл энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч, эзэмшигч, итгэмжлэн хариуцсан, хамгаалах үүрэг бүхий хүнээс өөртөө шилжүүлэн авахыг оролдох эсхүл авснаар гэмт хэрэг үйлдсэн гэж тооцогддог онцлогтой.

Энэ гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг байна. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байдаг.

Дээрэмдэх гэмт хэргийн хүндрүүлэх шинжид заасан гэмт хэрэг нь давхар объекттой гэмт хэрэг гэж үздэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл дээрэмдэх үйлдлийн улмаас хохирогчийн хуулиар хамгаалагдсан хэд хэдэн эрх, эрх чөлөө зөрчигдөж халдлагад өртсөн гэсэн ойлголт юм. Тухайлбал, өмчлөх эрхэд халдаж, улмаар хохирогчийн эрүүл мэндийн халдашгүй байдалд хохирол учруулж болно. Энэ тохиолдолд хохирогчийн өмчлөх эрх үндсэн, хүний эрүүл мэндийн халдашгүй байдал нь нэмэгдэл объект болно гэсэн ойлголт юм.

Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт:



дээрэмдэх
гэмт
хэргийг хүч
хэрэглэж



хүч
хэрэглэхээр
заналхийлж
авахаар
довтолсон



2-8 жил хүртэл
хугацаагаар
хорих ял
шийтгэнэ

Хүч хэрэглэж гэсэн ойлголт нь гэмт этгээд хохирогчийн бие махбодод халдаж, түүний эсэргүүцлийг няцаан эд хөрөнгийг авсан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодод халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, хоолойг боох зэрэг хэлбэртэй байж болно. Хүч хэрэглэсэн үйлдлийн улмаас хохирол бодитойгоор учраагүй боловч хүч хэрэглэсэн арга нь хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл бий болгохоор байсан бол энэхүү ойлголтод хамаатуулан үзэх үндэслэлтэй юм.

Харин хүч хэрэглэхээр заналхийлж бусдын эд хөрөнгийг авахаар довтолох гэдэг нь гэмт этгээд хөрөнгөө өгөхгүй бол түүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана гэх зэргээр айлган сүрдүүлж, довтолсон байхыг ойлгоно.

Энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинжийн тухайд хүчирхийлэл, довтолгоо нь хохирогчийн эсрэг чиглэсэн байх ёстой байдаг. Нөгөөтээгүүр гэмт хэргийн хүндрүүлэх шинж нь бусдын эд хөрөнгийг авч чадсан эсэхээс үл хамааран хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авах довтолгоо хийснээр төгс үйлдэгдсэнд тооцогдож тохирох эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял оногдуулна гэсэн ойлголт юм.

Дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхдээ хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан бол эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг тохирох гэмт хэргээр, хохирогчийг алсан бол хүнийг алах гэмт хэргээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг онцлогтой байдаг.



Дээрх хүндрүүлэх шинжийг дараах байдлаар тайлбарлаж болно⁷. Үүнд:

- Дээрэмдэх гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг тогтвортой буюу гурав, түүнээс дээш удаа үйлдэж олсон орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж байгаа ойлголт юм.
- Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглаж үйлдсэнийг ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгодог байна.
- Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс дээш хүний тогтвортой нэгдэл үйлдсэн дээрэмдэх гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хорих ял оногдуулдаг байна.

Кейс: Амгалан өөрийн хөрш Очирыг эзгүй байх хойгуур гэрт нь нууцаар орж БНХАУ-д үйлдвэрлэсэн 250.000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийн үнэ бүхий цахилгаан хөрөөг авчээ. Амгалангийн хулгай хийсэн болох нь илчлэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Амгаланг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-ээр хүндрүүлэх шинжээр зүйлчилсэн байна. Амгалангийн өмгөөлөгч Найдан миний үйлчлүүлэгч Амгалан нь гурван зуун нэгж буюу 300.000 /гурван зуун мянга/ төгрөг хүрэхгүй Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3 дахь хэсэгт заасан “бага хэмжээний хохирол” учруулсан тул Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг Прокурорын байгууллага хүлээж авалгүй Эрүүгийн хуулийн 17.1-2.1-д зааснаар зүйлчилж Эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Прокурорын үйлдэл зөв үү?

Шийдэл: Хулгайлах гэмт хэргийн үндсэн шинж нь бусдын өмлөх эрхэд бага хэмжээнээс дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаарддаг бол хүндрүүлэх шинжид заасан хулгайлах үйлдлийн улмаас хохирол учирсан байхыг шаардахгүй⁸. Тухайлбал, хүн байнга амьдрах орон байранд хууль бусаар нэвтэрч эд хөрөнгийг хулгайлсны улмаас бусдад бага хэмжээний

⁷ Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –УБ., 2018. 185 дахь тал.

⁸ Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –УБ., 2018. 183 дахь тал.

хохирол учирсан, учраагүй байсан ч хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинж буюу Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх тул Прокурорын үйлдэл зөв байна.

СЭДЭВ 4. ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Хүчиндэх гэмт хэрэг, хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн дотно харилцаа буюу бэлгийн амьдралын талаарх ухамсар зарим хүмүүсийн дунд өөрчлөгдөж хамтран амьдрагч, тохиолдлын бэлгийн харилцаанд тогтмол орох, эсрэг хүйстэн бус ижил хүйстэн сонирхох, улс дамнасан гэр бүл, нэгээс илүү эмэгтэй, эрэгтэйтэй харилцаа үүсгэхийн зэрэгцээ гэр бүлийн гишүүдийн ёс зүйн ухамсар доройтох, салалт нэмэгдэх, үр хүүхдэдээ тавих хяналт, хүмүүжил суларсан зэргээс үүдэн бэлгийн харилцааны сөрөг үзэгдэл буюу хүчээр бэлгийн харилцаанд орох асуудал буурахгүй байна.

Энэхүү сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн тулд эрүүгийн эрх зүйн салбар хүмүүнлэг эрүүгийн эрх зүйг бий болгох, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, түүнээс үүдэлтэй хүч хэрэглэсэн шинжтэй гэмт хэргийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ төрлийн гэмт хэрэгт зайлшгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай тулгарсаар байна.

Хүчиндэх гэмт хэрэг гэдэг нь эрх зүйн үүднээс тайлбарлавал хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан үйлдэл байдал тул Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм⁹.

Хууль тогтоогчийн зүгээс бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, хүчирхийллээс Эрүүгийн хуулиар хамгаалаад зогсоогүй бэлгийн харьцааг ёс бус, ашиг олох, бурангуй гаж үйлдэл, өсвөр насны охидын эрүүл өсөлт бойжилт, сэтгэл зүй, хүмүүжил, зан суртахуунд сөрөг үр дагавар учруулахаас урьдчилан сэргийлэхийг зорилго болгосон байдгаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл бэлгийн хүчирхийллийн хохирогч нь урт, удаан хугацааны туршид эсрэг хүйсийн хүнд итгэх итгэлгүй, айдас түгшүүртэй болгох, сэтгэцийн хувьд хүнд гэмтэлд орох, амьдралын ирээдүйн зорилго чиглэл өөрчлөгдөх,

⁹ Гантулга, С. Эрүүгийн эрх зүйн Тусгай анги сурах бичиг. -УБ., 2018. 56 дахь тал.

өөрийгөө гаргуунд гаргах буюу өөрийгөө хэнд ч хэрэггүй мэт ойлгох, ирээдүйд итгэх итгэл алдрах, ажил, хичээл сургууль завсардах зэрэг байдлаар бүхэл бүтэн хүний амьдралыг өөрчлөх хүртэл хүнд цохилт болдог хор уршигтай гэмт хэргийн нэг юм.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал гэх ойлголт аль ч хүйсийн хүнд хамаарах хэн ч халдашгүйгээр хуулиар хамгаалагдсан, зөвшөөрөгдсөн харилцаа төдийгүй хайр дурлал, итгэл, хүндлэл зэрэг хүний нийгмийн ёс суртахуунаар давхар хамгаалагдаж, зөрчсөн буруутай этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцож, харьцангуй хатуу ял оногдуулахаар эрэмбэлсэн нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын харилцааг зөрчихөөс эрүүгийн хуулиар хамгаалж буй хэлбэр юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Хүчиндэх гэмт хэрэг гэдгийг тодорхойлохдоо:



Энэхүү нөхцөл байдалтайгаар бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заажээ.

Харин энэхүү гэмт хэргийг хүндрүүлэх шинжийн Эрүүгийн хуулийн 12.1.2 дахь хэсэгт дараах байдлаар зааж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.



Харин энэхүү гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон, гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх бол хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёроос хорих жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэх эрх зүйн зохицуулалтай байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг, хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэсэн нэр томъёог хэл зүйн талаас нь үзвэл ёс бус үйлдэл хэвшиж тогтсон ёс журмыг сахихгүй байхыг хэлнэ хэмээн тодорхойлжээ.

Эрдэмтэн, судлаачид бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах ойлголтыг хэрхэн тайлбарласныг авч үзвэл, академич С.Нарангэрэл "... бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах нь эрийг эмлэх, /эрэгтэй хүн ижил хүйстэнтэйгээ харьцаж бэлгийн дур хүслээ хангах/, зодож занчих, юмаар ороолгох, гуядах, тамхины галаар түлэх, хазах замаар бэлгийн дур хүслээ хангах зэргээр илэрнэ. Ёс бус гэсэн асуудлыг шийдвэрлэхэд сексопатолог эмчийн оролцоотой шинжилгээ хийлгэж болно...", доктор С.Жанцан "... бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэг бол хохирогчийг тохуурхан доромжилж хүн төрөлхтний биологийн заяагдмал ёсноос гадуур дур хүслээ хангах үйлдэл" гэжээ.

Улсын Дээд Шүүхийн 1989 оны 26 дугаар тогтоолд "бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах нь гэмт этгээд хохирогчийг хүчиндэх, түүнтэй эр эмийн ёсоор хурьцал үйлдэх зорилгогүйгээр өөрийн шалиг завхай дур сонирхолдоо хөтлөгдөн бэлгийн харьцааны замаар бус садар самуун

байдлаар хохирогчийн бие эрхтнийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангах байдлаар илэрнэ. Насанд хүрээгүй болон бага насны хүүхдийн биеэ хамгаалж чадахгүй буюу уг үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүйг далимдуулан бэлгийн дур хүслээ хангасан, хохирогчийн цавь гуяны завсар дур хүслээ хангасан үйлдэл нь бэлгийн харьцаанаас гадуур хүслээ хангасанд хамаарахыг..." тайлбарласан байдаг.

Дээр дурдсанаас үзэхэд "Ёс бус" гэх ойлголтод хэвшиж тогтсон ёс заншлаас гадуур, зүй бус, гаж байдлыг хамааруулж болох ба эр, эмийн ёсноос гажууд буюу хэвийн бус үйлдлүүд хийснийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасанд тооцох үндэслэлтэй байна.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шинжийг 2015 оны Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дэх хэсэгт тодорхойлсон байна.

Уг гэмт хэргийн заавал байх шинж нь:



Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах сэдэлт зорилгоо хохирогчийг илтэд басамжлах, доог тохуу хийхэд чиглэгдсэн гэмт санаа, элдэв бүдүүлэг аргаар хэрэгжүүлсэн байхыг тохуурхан доромжилсон утга агуулгад хамруулан ойлгодог байна.

Гэм буруугийн шинж нь санаатай хэлбэртэй, хохирогчтой харилцан тохиролцож бэлгийн харьцаанд орсон байх үедээ хохирогчийн хүсэл зоригийг үл харгалзан гаж буруу байдлаар өөрийн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангахыг хүсэж үйлдсэн байдаг онцлогтой.

2015 оны Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэргийн шинжийг:

- Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүчээр бэлгийн харьцаанд орсон;
- Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол гэсэн 2 хэлбэрийн шинжээр ялгамжтайгаар зохицуулсан. Мөн "бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл" гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлгэ эрхтнээ оруулсан үйлдэл юм.

Энэхүү гэмт хэрэг нь хүчиндэх гэмт хэргээс ялгагдах ялгаань хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орсон үедээ эсрэгээр хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл юм.

Бага насны буюу 14 хүртэлх насны хүүхдийн хувьд бэлгийн харьцааны ойлголт, учир холбогдлыг огт мэдэхгүй, зөвшөөрлийн тухай асуудал огт яригдахгүй учраас бага насны хүүхдийн эсрэг “бэлгийн дур хүслээ хангах” буюу бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн нь хүчиндэх гэмт хэргийн шинжийг хангасан гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй юм.

Хэрэв 14 насанд хүрсэн хүн 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийг үйлдэх явцдаа тухайн хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан тохиолдолд хүчиндэх гэмт хэрэгтэй нийлмэлээр зүйлчилнэ.

Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх эрх зүйн зохицуулалтай.

Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаатай хорих ялаар шийтгэх бол бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн нь тогтоогдвол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж эрүүгийн хуульд заажээ.

Кейс: Таксины жолооч Сэргэлэн 15 настай Анужин гэгч охиныг үнэгүй хүргээд өгье гээд машиндаа суулган явж байгаад замдаа хурьцал үйлдсэн байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Сэргэлэн мэдүүлэг өгөхдөө “Анужин бид хоёр тохирч хурьцал үйлдсэн, би түүнийг 15 настай гэж мэдээгүй” гэсэн бол Анужин мөн мэдүүлэг өгөхдөө тохиролцож бэлгийн харьцаанд орсноо хүлээсэн байна. Сэргэлэн гэмт хэрэг үйлдсэн үү.

Шийдэл: Сэргэлэн бэлгийн харьцаанд орохоосоо өмнө Анужиныг хэдэн настай болохыг асууж, мэдэх боломжтой байсан. Иймд Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан тул гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

СЭДЭВ 5. ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Хүүхэд болон гэр бүлийн сайн сайхан аж төрөх нөхцөлийг хангах нь төрийн чиг үүргийн нэг хэсэг мөн. Монгол Улсын Үндсэн хуулиар эх, нялхсыг төрийн хамгаалалтад авсан байдаг. Хүүхэд бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны хувьд төлөвшин хөгжих нөхцөлийг хангахад иргэн бүрийн оролцоо чухал үүрэгтэй.



Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт хүүхдийн эсрэг гэмт хэрэг гэдэгт дараах гэмт хэргийг зааж өгсөн болно. Үүнд:



Энэхүү гэмт хэргийн гол объект бол хүүхдийн бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны хувьд зөв хүмүүжүүлэх гэр бүл аж төрөх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн иргэн хоорондын буюу өргөн утгаараа нийгмийн харилцаа бөгөөд үүнээс дараах тодорхойлолтууд урган гарч байна.

Хүүхэд хамгаалал: Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан тохиолдолд хамгаалах, хариу арга хэмжээ авах тогтвортой үйл ажиллагаа;

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл: Хүүхдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэл (бие махбод, сэтгэл санаа, бэлгийн) үл хайхрах байдал, бүх төрлийн мөлжлөг гэх мэт хүүхдийн бие махбод, сэтгэл санаанд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл, эс үйлдэхүй;

Үл хайхрах: Хүүхдийн сэтгэл санаа, бие махбод, эрүүл мэнд, хөгжил, аюулгүй байдлыг хангах суурь хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан бол учруулахаар завдсан эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдлийг;

Мөлжлөг: Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, боловсролд хохирол учруулах хөдөлмөр, үүний тэвчишгүй хэлбэрүүд, биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн хүчирхийллийн шинжтэй бусад үйлдлүүд үзүүлэх, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлолын төсөөтэй үйлдэл, эрх чөлөөгүй байдалд байлгах, эд эрхтнийг нь авах зэргээр ашиг хонжооны хэрэгсэл болгохыг;

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт: Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5-11 насны, хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж байгаа 12-14 насны, 7 хоногт 43, түүнээс дээш цагаар ажиллаж байгаа 15-17 насны бүх хүүхдийг;

Аюултай хөдөлмөр эрхлэлт: Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий аливаа үйл ажиллагааг, мөн уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар ажиллаж байгааг;

Хор хөнөөл: Эрх мэдэл, нас, эд хөрөнгө зэрэг хүүхдээс илүү давуу талаа ашиглан бие махбод, сэтгэл санаа, бэлгийн дарамтад оруулж хүүхдэд хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэхүйг тус тус ойлгоно.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага:

Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 18 насанд хүрсэн хүн хүүхдийг зохион байгуулалттай гэмт бүлэгт, 8 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр

заасан гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тус гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэсэн бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тус гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхдээр гуйлга гуйлгасан бол 240 цагаас 480 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Харин хүүхдийг санаатайгаар сольсон бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол 10000 нэгжээс 40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

18 насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн бол 450 нэгжээс 1300 тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас долоон 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Тус гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол 450 нэгжээс 2700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тус гэмт хэргийг кибер орчныг ашиглаж, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол 10000 нэгжээс 40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол 2700 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол 450 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Тус гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол 5400 зуун нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөн гэмт хэргийн улмаас хүүхэд нас барсан бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр эрүүгийн хуульд тусгажээ.

Кейс: 20 настай Дорж нь орцныхоо зарим хүүхдүүдэд цавуу үнэрлэх нь сайхан мэдрэмж төрүүлдэг талаар ярьж, улмаар тухайн хүүхдүүд байнга цуглаж цавуу үнэрлэдэг болсон байна.

Шийдэл: Эрүүгийн хуулийн 16.2.1-д “хүүхдийг байнгын согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан тул Дорж эрүүгийн хариуцлага хүлээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЭЛЖ, ЯЛТАНД ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

СЭДЭВ 1. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын нийтлэг үйлчлэлийн талаар дурдвал хүний уураг тархинд шууд давамгайлан нөлөөлж төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг зохиомлоор цочроох, сэтгэцийн хөөрөл, зохиомол баясал /эйфория/, хий үзэгдэл буюу цагаан солио үүсгэх эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг дарангуйлан саатуулах байдлаар булчин сулруулах, нойр хүргэх, мэдрэл тайвшруулах, сэтгэлийн түгшүүрийг номхотгох зэрэг зохиомол үйлчлэлийг үзүүлэх чадварыг өөртөө шингээсэн байдаг.

Энэхүү эм, бодисын хэрэглээг эмнэлгийн бус зориулалтаар замбараагүй хэрэглэх нь биеийн болон сэтгэцийн шууд хамааралд оруулж, донтох, эмгэгт хүргэдэг төдийгүй шууд үхэлд хүргэх аюултай гэсэн үг юм.

Монгол Улс нэгдэн орсон гэрээний дагуу үхлийн аюултай, хүний сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах бодисын эсрэг Мансууруулах бодисын тухай 1961 оны нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцын тусгай нэрийн жагсаалтад орсон эсэхийг шалгаж, тэмцэх ажлыг эрчимтэй хэрэгжүүлж байдаг.

Тэгвэл мансууруулах бодисыг байнга буюу тогтмол байдлаар хэрэглэвэл хараат байдал оруулдаг төдийгүй хүний сэтгэл зүйн байдлыг өөрчлөх чадвартай ургамал, нийлэг гаралтай бодис гэж үздэг.

Мансуурал гэж юу вэ?


Мансуурал гэдэг нь сэтгэцэд нөлөөлөх бодис юм уу мансууруулах үйлчилгээтэй эмийн бодисуудаас болж хараат байдалд орсноос үүсэх өвчин, эмгэг юм.



Мансууруулах сэтгэгцэд нөлөөт бодисыг хэрэглэх шалтгаан, нөхцөл:

- Хотжилт даяаршлын нөлөөн дор хүүхэд залуучуудын дунд бие биеэ буруугаар үлгэрлэн дуурайх буюу энэхүү үхлийн аюул, хор уршгийн талаарх мэдээлэлд төөрөгдсөн буюу буруу ташаа ойлголттой байсан;
- Энэ төрлийн эм бодисын хяналтгүй, буруу хэрэглээ
- Хүмүүжлийн буруу хэв шинж, гэр бүл, ойр дотнын хүрээллийн сөрөг нөлөөлөлд автсан, сониуч зантай
- Стресст өртөх, тайлах буруу хэвшилтэй зэргийг дурдаж болно.

Хор уршиг эрүүл мэндэд нөлөөлөх байдлаар (хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд):



Донтолтын тухай ойлголт:

Донтолт гэдэг нь аливаа зүйлийг хэт хэрэглэснээс эсвэл аливаа үйл ажиллагаанд хэт татагдан орсноос үүдэлтэй сэтгэцийн хамааралтай болох тогтонги буюу дахин давтагдах шинжийг хэлдэг байна. Уг хэрэглээ /үйлдэл/ нь тухайн хүнд таашаал өгч буй хэдий боловч удаан хугацаагаар хэрэглэвэл /оролцвол/ хүн өөрийн хяналтаа алдаж, амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нь саад учирдаг хамааралтай болгодог хэвшил юм.

Донтолтын хэмнэл үүсэх үед сэтгэл зүйн таагүй байдал нь донтолтын давтамжтай хэмнэлийг нэмэгдүүлдэг. Тухайн хүний биеийн хүч, сэтгэл зүйн болон сэтгэхүйн хэв шинж онцлог түр зуурын бэрхшээлийг даван туулах чадвар зэргээс шалтгаалдаг байна. Хүний амьдралд олон асуудал тохиолдоно. Үхэл хагацал, өр шир, хайр дурлал гээд стрессээ тайлах аргаа буруу сонгосноос нөгөө үйлдлээ дахин давтаж хэмнэл үүсгэдэг. Ийм үед тухайн хүнд ямар нэгэн зүйл сонирхол татахаа больж, заавал ямар нэгэн орлуулах зүйлийг хайх шинж тэмдгүүд илэрдэг.

Донтолт төлөвших үед хүний сэтгэл зүйн байдал маш их нөлөөтэй. Доторх зөрчлөө нэг хэлбэрийн донтолтын нөлөөгөөр солих санаа төрдөг. Донтох эмгэгт автах үед аажмаар бусдаас өөрийгөө тусгаарладаг. Ажил хэргийн холбоотой хүмүүстэйгээ учир зүйгээ олохоо байж, алхам бүрдээ асуудал, хүндрэл бэрхшээлтэй тулгарч байдаг.

Донтох эмгэгийн үед бие, сэтгэлийг бүхэлд нь нөлөөндөө оруулдаг. Аливаа донтолт нь хүнд түрхэн зуурын сэтгэлийн таашаалыг өгч байгаа хэдий боловч угтаа хүний амьдралыг бүрмөсөн сүйрүүлж тэр ч бүү хэл удамших магадлалтай байдаг билээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах” үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил

хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргийн байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй гэж хуульчилжээ.

Кейс: Дугаар хорих ангийн ногооны хэсэгт ажилласан хоригдол Хүнбиш хар тамхины ургамал буюу каннабис байсныг олж ял шийтгэгдсэн хоригдол Мянгандбаярт өгөх зорилгоор хорих ангийн хамгаалалтын бүсэд нэвтрүүлэх гэж байсныг хамгаалалтын ажилтан Билгүүн илрүүлэн хураан авч, хоригдол Хүнбишид ямар нэг хариуцлага тооцолгүй өнгөрөөсөн байна. Хамгаалалтын ажилтан Билгүүний үйлдэл зөв үү?

Шийдэл: Хамгаалалтын ажилтан Билгүүний үйлдэл буруу байна. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасны дагуу хоригдол Хүнбишийг холбогдох албан тушаалтанд танилцуулж, харьяа орон нутгийн цагдаагийн байгууллагаар шалгуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой.

СЭДЭВ 2. ОЛОН НИЙТИЙН АМГАЛАН ТАЙВАН БАЙДЛЫГ АЛДАГДУУЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Монгол Улс нь ардчилсан Үндсэн хуульдаа “Эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон” тунхагласан нь хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг өндөрт өргөн, тэдгээрт чөлөөтэй хөгжих, амьдрах бололцоог бий болгож түүний баталгааг бүрдүүлэх явдал нь нэн тэргүүнд биеллээ олох учиртай юм. Учир нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм гэдэг бол “нийгэмд хүний эзлэх байр суурийг бүхний дээр тавих, эрх чөлөө, чөлөөт хөгжил сайн сайхан байдлыг эрхэмлэн дээдлэх, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд бүтээсэн үнэт зүйл бүхнийг хүний төлөө зориулах нийгмийн байгуулал”¹⁰ хэмээн тодорхойлсон байдагтай холбоотой.

Иймд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцдаг¹¹ тул төр эл үүргээ хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг тогтоон, хамгаалах, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол болох тухайн нийгмийн үнэт зүйлээ гэмт халдлагаас буюу хууль бус үйлдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх байдлаар илэрдэг.

Аливаа ард түмэн улс гэр, эх орон дотроо айх аюулгүй амар амгалан байлгахад чиглэсэн зохицуулалттай эрх зүйн нэгэн томоохон салбар бол эрүүгийн эрх зүй¹² бөгөөд эрүүгийн хууль бол төрийн хууль тогтоох дээд байгууллагаас зөрчихийг хатуу хориглож, зөрчсөн нөхцөлд хэрэглэх албадлагын төрлүүдийг хуульчлан тогтоосон эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цог юм¹³.

Хувь хүний эрх, эрх чөлөө түүний дотор эрүүл аюулгүй орчинд чөлөөтэй амьдрах, хөдөлмөрлөх эрхийг хангах, аливаа гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс сэргийлэх асуудлыг тэргүүн зорилго болгон түүний төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь улс орон бүрийн урдаа тавьсан тэргүүн зорилго болдог бөгөөд эрүүгийн хууль тогтоомждоо нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан тохиолдолд түүнийг гэмт хэрэг гэж үзэн таслан зогсоож цаашид энэ чиглэлээр хууль тогтоомжоо улам бүр боловсронгуй болгож байдаг.

Нэрт соён гэгээрүүлэгч Чезаре Беккариа нийгмийн амгалан тайван байдлын талаар дүгнэн хэлэхдээ “... иргэдийн хувийн болон нийгмийн

¹⁰ Совд, Г. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. -Уб., 2000. 14 дэх тал.

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

¹² Нарангэрэл, С. Хууль зүйн толь бичиг. -Уб., 2008. 610 дахь тал.

¹³ Доржпалам, Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. -Уб., 2019. 10 дахь тал.

амгалан тайван байдлыг алдагдуулсан, арилжааны зах, гудамж талбай зэрэг олон нийтийн газар үймээн самуун дэгдээх, зодоон цохион үүсгэх, сонсож үймэх хүний тоо нь олон байх тусам өдөөх хүн нь нэмэгдэж байдаг бусдыг бослого самуунд уриалах зэрэг хэргүүдтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх учиртай талаар тайлбарласан байдаг.

Манай улсын хувьд ч нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах явдалтай эрс эсэргүүцэн эрүүгийн хууль тогтоомжоороо гэмт хэрэгт тооцон түүнтэй тэмцсээр ирсэн билээ.

1961 оны Эрүүгийн хуулиас хойш "Танхайрах" хэмээн нэрлэж заншсан гэмт хэргийг "олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах" гэж нэрлэж, 2002 оны Эрүүгийн хуульд танхайрах гэт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг "Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн" хэмээн тодорхойлж байсан бөгөөд шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйлд "Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх, эд хөрөнгө өмчлөх эрхийг зөрчиж, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан гэж өөрчлөн хуульчилсан.

Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийг үйлдлээ хэрэгжүүлсэн арга, бусдын эд хөрөнгөд учирсан хохирол зэргийг нь харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилсан.

1. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалгүй, үндсэн шинжээр үйлдсэн гэдэгт дараах ойлголтыг авч үзнэ.

Олон нийтийн амгалан тайван байдал:

Уг ойлголт нь хэл зүйн талаасаа хоршоо үг бөгөөд агуулгаараа бие сэтгэл зовлон зүдүүргүй байх төлөв¹⁴ хэмээн үг зүйн тайлбар хийж болохоор байна. Харин хууль зүйн шинжлэх ухааны нэр томъёо болохын хувьд уг ойлголтыг системчлэн тайлбар хийх нь зүйтэй. Уг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20 дугаар бүлэг буюу "Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг" гэх бүлэгт хуульчилсан байдаг. Иймд дээрх ойлголт нь олон нийтийн аюулгүй байдал гэх ойлголттой төрөл, дүрсийн хамааралтай гэж үзэж болохоор байна. Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан гэж гэмт этгээд нийгэмд тогтсон иргэн бүр заавал дагаж мөрдвөл зохих эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээ, түүнчлэн онцгой хүндэтгэл шаардах үндэсний ёс заншил уламжлалт ёс горимыг хүндэтгэхгүй байх, хувийн явцуу ашиг сонирхлыг нийгэм, хамт олны ашиг сонирхлын

¹⁴ Цэвэл, Я. Монгол хэлний тайлбар толь. -Уб., 1966. 38 дахь тал.

эсрэг сэргүүлэн тавьж, энэ үйлдлээ орчны хүмүүст илт мэдэгдэхүйц байхаар нөхцөл хийхийг ойлгоно¹⁵.

Олон нийтийн аюулгүй байдал:

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан, хүний амь нас, эрүүл мэндэд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон иргэн аж ахуй нэгж, байгууллагын ашиг сонирхол, дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс хамгаалагдсан байдал¹⁶-ыг ойлгохоор бичсэн байдаг. Харин олон нийтийн амгалан тайван байдал аюулгүй байдлаас зарчмын болон агуулгын хувьд ялгаатай ч эдгээр нь төрөл дүрсийн хамааралтай буюу аюулгүй байдал гэх ойлголт илүү өргөн цар хүрээтэй ойлголт юм.

Нийтийн хэв журам:

Нийтийн хэв журам гэдэг нь олон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв журам¹⁷ бөгөөд энэ ойлголт нь нийгмийн хэв журам гэсэн ухагдахуунаас зарчмын шинжтэй ялгаа зааг байхгүй. Нийгмийн хэв журам гэх ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 19.3 дугаар зүйлд хуульчилсан бөгөөд энэ нь нийтийн газар дахь аюулгүй байдлын нөхцөл буюу тодорхой бус тооны олон хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулахад чиглэнэ. Нийгмийн хэв журам нь хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх, бололцоог хангах, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан Монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэл тогтолцоо юм¹⁸.

Бүлэглэн:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ” хэмээн хуульчилсан бөгөөд энэ нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийг заавал байх шинжийн нэг нь бөгөөд танхайрах зөрчлөөс ялгагдах шинж болдог.

Хүч хэрэглэж:

Хүч хэрэглэсэн гэдэгт хүнийг зодох, бие эрхтэнд нь гэмтэл учруулах зэрэг биеийн хүч хэрэглэсэн аливаа үйлдлийг ойлгоно¹⁹ хэмээн тайлбарласан

¹⁵ Гантулга, С. Энхболд, Б. Эрүүгийн эрх зүйн /тусгай анги/ -УБ., 2018. 338 дахь тал.

¹⁶ Долгорсүрэн Ж. Цагдаагийн эрх зүйн курс. -УБ., 2014. 39 дэх тал.

¹⁷ Золбоо, Т. Сургалтын эрүүгийн хууль. -УБ., 2017. 143 дахь тал.

¹⁸ Адъяабазар, Д. Танхайрах гэмт хэрэг /сургалтын гарын авлага/ -УБ., 2007. 36 дахь тал.

¹⁹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. -УБ., 2010. 469 дэх тал.

бөгөөд гэмт этгээд хохирогчийн бие махбодод халдаж, түүний эсэргүүцлийг няцаасан байхыг ойлгоно. Ингэхдээ алгадах, цохих, өшиглөх, хоолойг боох, зэрэг хэлбэртэй байж болно гэж тайлбарласнаас үзвэл хүч хэрэглэж үйлдэх гэдэг нь субъект булчингийн үйлчлэлийн тусламжтайгаар хууль бусаар бусдад халдсан үйлдсэн байхаар хуульчилсан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална хэмээн хуульчилсан бөгөөд эд хөрөнгө гэх ойлголт нь эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдах ч иргэний эрх зүйг бие даасан судлагдахуун юм. Монгол Улсын Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт Аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө гэнэ гэсэн бөгөөд эзэмшил гэдэг нь хуулийн 89.1 дэх хэсэгт Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ гэснийг тус тус баримтлах нь зүйтэй.

Эд хөрөнгө устгах, гэмтээх:

Эд хөрөнгө устгах гэж бүрэн устгах эсхүл зориулалтын дагуу ашиглах боломжгүй болгохыг ойлгодог бол эд хөрөнгө гэмтээх гэж тухайн эд хөрөнгийн анхны байдал, чанар муудаж, алдагдсан боловч эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах боломжийг алдагдуулаагүй буюу дахин засварлах шаардлагатай болгосон байдгаар ялагдана.

Өдөөн турхирч:

Энэ нь нийтийн хэв журам зөрчих, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад бусад хүн олон нийтийг уриалан дуудсан үйл ажиллагааг мушгин гуйвуулж олон нийтийн эсрэг сөргүүлэн тавьсан байхыг ойлгох²⁰ нэгэн төрлийн үйлдлийн арга юм.

Татан оруулах:

Уг арга нь урьдчилан амлах, хууран мэхлэх, заналхийлэх, хүч хэрэглэх гэсэн хэлбэрүүдтэй байж болох бөгөөд нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэх, эсхүл эд хөрөнгө устгах, гэмтээх үйлдэлд оролцуулсан идэвхтэй үйлдлээр илэрнэ.

Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13-д хүний халдашгүй байх эрх нь хүн бүрд Үндсэн хуулиар баталгаажсан, хөндлөнгөөс ямар ч этгээд дур мэдэн зөрчихгүй байх туйлын шинжийг илэрхийлэх бөгөөд орон байрны, захидал харилцаа болон хувь хүний чөлөөтэй зорчин явах эрхэд халдсан,

²⁰ Гантулга, С. Энхболд, Б. Эрүүгийн эрх зүйн /тусгай анги/ -УБ., 2018. 336 дахь тал.

хязгаарласан, саад учруулсан байхыг ойлгоно. Бие махбодын халдашгүй байх эрх чөлөөт хүнээр аливаа үйлдлийг хүчээр хийлгэх, эс хийлгэхийн тулд дарамтлах, албадах, өвтгөн зовоох хэлбэрээс ангид байх туйлын шинжийг агуулдаг.

Эд хөрөнгө өмчлөх эрх:

Энэ эрх нэгэн төрлийн жам ёсны бөгөөд туйлын эрх билээ. Энэ эрхийн агуулга нь эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэсэн эрхийн бүрдлээс бүрддэг²¹. Товчхондоо хэлбэл өнөө үед аливаа эд хөрөнгийг өөрийн үзэмжээр, хуулиар олгогдсон хэмжээ хязгаарын дотор хүссэн бүхнээ хийх боломжтой туйлын эрх юм. Эд хөрөнгө өмчлөх эрхийг зөрчсөн гэж эд хөрөнгөө эзэмших, ашиглах эрхтэйн дээр түүнийг захиран зарцуулах бүрэн эрхийг эдэлдэг. Эд хөрөнгө захиран зарцуулах эрх гэдэг бол өмчлөгчийн бүрэн эрхийн гол агуулга бөгөөд тухайн эд хөрөнгийн хувь заяаг хэнээс ч хараат бусаар хуульд заасны дагуу бие дааж саад учруулж, хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байхыг ойлгоно.

Аж ахуй нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан:

Хуулиар хүлээсэн болон өөрийн дүрмээр тодорхойлсон чиг үүргээ хэвийн гүйцэтгэхэд саад учруулсан үйл ажиллагааг нь тасалдуулсан албан хаагч, үйлчлүүлэгчдийнхээ эрх ашгийг хохироосон үйлдлийг ойлгох бөгөөд аливаа хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилготой юм.

Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэж, эсхүл эд хөрөнгө устгаж, гэмтээж, эсхүл эдгээр үйлдэлд өдөөн турхирч, татан оруулж хүний халдашгүй, чөлөөтэй байх, эд хөрөнгө өмчлөх эрхийг зөрчиж, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

²¹ Давхарбаяр, Ц. Эдийн баялгийн эрх, эд юмсын эрх. -УБ., 2017. 77 дахь тал.

2. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүний онцлог:



Кейс: 18 насанд хүрээгүй хэсэг хүүхэд нийлж орцонд гитар тоглон дуулж байтал байрны нэгэн эмээ та нар яах гэж энд цуглаад байдаг юм бэ эндээс яв гэж хөөсөнд хүүхдүүдийн зүгээс одоо дөнгөж 16 цаг болж байна орой ч болоогүй байна, бид чанга дуулаагүй байхад та яагаад хөөгөөд байгаа юм. Тэгээд ч орц бол нийтийн өмч таны гэрт ороогүй гэх зэргээр хэрүүл маргаан үүсгэсэн байна. Олон нийтийн цагдаа ирж хүүхдүүдийн үйлдлийг зогсоох шаардлага тавихад та жинхэнэ цагдаа биш байна гэх зэргээр эсэргүүцсэн байна. Энэ үйл явдалд дүгнэлт хийнэ үү?

Шийдэл: Цагдаагийн алба хаагч, олон нийтийн цагдаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчлийг арилгуулах, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх зорилгоор хүн, хуулийн этгээдэд тодорхой үйлдлээс татгалзах, эсхүл үйлдэл хийх шаардлага тавьж болно, тавьсан шаардлагыг иргэн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй гэж Цагдаагийн албаны тухай хуульд заасан тул олон нийтийн цагдаагийн алба хаагчийн шаардлага хууль зүйн үндэслэлтэй байна.

Хүүхдүүдийн хувьд Зөрчлийн тухай хуульд заасан “Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах” гэсэн заалтыг зөрчөөгүй боловч мөн хуулийн 5.2-д заасан олон нийтийн газарт


хэрүүл маргаан үүсгэж танхайрах зөрчил гаргасан байх үндэслэлтэй байна. Хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хараа хяналтдаа байлгах, сурган хүмүүжүүлэх, удирдах чиг үүрэг бүхий хүнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдуулахгүй байх талаар үүрэг чиглэл өгөх хэрэгтэй.

СЭДЭВ 3. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн тухай:

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэсэн хорин долоодугаар бүлэгт заасан гэмт хэрэг юм.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг нь дараах шинжтэй байх бөгөөд аль нэг шинж нь байхгүй тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн гэж үзэх боломжгүй юм.



1. Тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцсон байх (жишээ нь, зогсож буй тээврийн хэрэгслийн тэвш дээрээс хүн үсэрч буухдаа гэмтэх нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг болохгүй);
2. Осол болох үед тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцсон

байх (замын хөдөлгөөнөөс тусгаарлагдсан хаалттай хашаа, үйлдвэрлэлийн талбай зэрэг нь замын хөдөлгөөнд хамаарахгүй);

3. Осол болох үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн хэмжээний нэг буюу хэд хэдэн заалт зөрчигдсөн байх (Эрүүгийн хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, норм ба дүрэм гэх мэт);
4. Ослын улмаас тодорхой хохирол учирсан байх (хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл, ачаа, замын байгууламж зэрэг эвдэрч гэмтэх гэх мэт).

Авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг гэдэг нь хөдөлгөөний аюулгүй байдал, техник, ашиглалтын журам, тээврийн хэрэгсэл, Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай гэмт буруутай үйлдэл, эс үйлдэхүй байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчиж, бусдын амь нас, эрүүл мэнд, өмчлөх эрхийг механикжсан тээврийн хэрэгслээр хохироосон үйлдэл нь гэмт хэрэгт тооцох үндэслэл болох юм.

Энэ төрлийн гэмт хэрэг хариуцлага хүлээх тэгээд нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд байхаар хуульчилсан.

Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж Эрүүгийн хуулийн 27.10.1 дэх хэсэгт заасан.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг согтуурсан, мансуурсан үедээ, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн, хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцно.

Их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн

хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж тус тус заасан байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам:



Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэмт хэргийн тухай

Улс орны болоод иргэдийн амьдрал ахуй дээшилж тэр хэрээр шинжлэх ухааны ололт, техник технологийн дэвшил манай орны янз бүрийн салбарт эрчимтэй нэвтэрч байна. Үүний нэг тод жишээ нь авто зам, тээврийн салбар юм. Өнөөдөр манай улсад нэг хүнд ноогдох машины тоогоор дэлхийд тэргүүлж байна. Айл өрх бүр 1-2 авто машин эзэмшиж байна. Авто машины тоо өсөн нэмэгдэхийн хэрээр авто тээврийн осол ихээр гарч, гэмтэж бэртэж байгаа болон нас барж буй хүний тоо ихээр нэмэгдэж байна.

Зам тээврийн осол, гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн газраас эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор зугтах, зайлах явдал нь ихээр гарах болсонтой холбогдуулан 2015 оны Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэгт Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах гэсэн нэр томъёогоор хуульчилсан.

Харин Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт "жолооч" гэдэг нь



Эрүүгийн хуулийн 27.10 дахь хэсэгт заасан Авто тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан, энэ гэмт хэргийг согтуурсан, мансуурсан үедээ, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн, хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, их хэмжээний хохирол учруулж үйлдсэн, энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон үйлдлийг нуун далдлах зорилгоор авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолоочид Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн жолооч хэргийн газрыг зориуд орхиж зугтаасан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж хуульчилжээ.

Тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид яаралтай тусламж үзүүлээгүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдээгүй, эсхүл хэргийн газраас зугтаасан бол Эрүүгийн хуульд зааснаар давхар зүйлчилнэ.

Харин жолоочтой цуг явсан этгээд осол болсныг болон хохирогчийн биед гэмтэл учирсныг мэдсээр байж түүнд яаралтай тусламж үзүүлээгүй, эсхүл тусламж үзүүлэх шаардлагатайг зохих байгууллагад мэдэгдээгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

“Хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлээгүй” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд зам тээврийн осол гаргасны дараа хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай болсныг мэдсэн бөгөөд туслах бололцоо байсан атлаа түүнд эмнэлгийн анхны тусламж

үзүүлээгүй, түргэн тусламж дуудаагүй, осол болсон газарт ойр байгаа эмнэлгийн байгууллагад аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу зайлшгүй тохиолдолд өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэх арга хэмжээ аваагүй зэргийг хамааруулан ойлгоно. Мөн зүйл, хэсгийн **“хэргийн газраас зугтаасан”** гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд зам тээврийн осол гаргасан үйлдлээ нуух, хариуцлагаас зайлсхийх зорилгоор ослын газрыг тээврийн хэрэгслээр, эсхүл явганаар санаатай орхиж явсан үйлдлийг хэлнэ.

Харин ослын улмаас тээврийн хэрэгсэл жолоодож явсан этгээд өөрөө гэмтсэн учраас хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлж чадаагүй, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх боломжгүй байсан бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний дүрэмд зааснаар:



Монгол Улсын хэмжээнд 30 жолооч тутмын 1 нь зам тээврийн осолд өртсөн байдаг. Иймд, та ч эрсдэлтэй нүүр тулахыг үгүйсгэхгүй. Зам тээврийн ослын хэлбэрээс үл хамааран тухайн хүн стресст автдаг. Харин стресст автсан үед тархи нөхцөл байдлыг бодитоор дүгнэж чаддаггүй сул талтай. Ослын дараах эхний 10 минут хамгийн чухал бөгөөд энэ хугацаанд та зөв шийдвэр гаргах хэрэгтэй болно.

Ослын дохиог асаах: Зам тээврийн осол болсон даруйд ослын дохиогоо асааж, ослын тэмдгийг тавьж хөдөлгөөнд оролцож буй бусад жолооч нарт анхааруулга өгөх хэрэгтэй. Ингэснээр та бусдыг сэрэмжлүүлж, дахин нэг

зам тээврийн осол болохоос урьдчилан сэргийлэх юм. Мөн хэрэв таны зорчигч гэмтсэн бол, та ослын гэрч болсон бол түргэн тусламжид яаралтай дуудлага өгөх шаардлагатай;

Цагдаагийн байгууллагын 102 дугаарт залгаж дуудлага өгөх, яаралтай түргэн тусламжийн 103 дугаарт залгаж дуудлага өгөх;

Даатгалын компанитайгаа холбогдох: Өөрийн даатгуулсан компанитай холбогдож ослын талаар мэдээлэл өгч, шаардлагатай баримтуудыг илгээгээрэй! Үүнд: ослын нөгөө талын хувийн мэдээлэл, бичиг баримтыг хуулбар, хохирол үнэлгээний тайлан, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, ослын акт мэдэгдэл зэрэг багтана. Мөн ослын нөхцөлийг тод харуулсан зургийг 8 талаас холбогдогчийг болон зам байдлыг оруулан алслан авах, 2 минутын бичлэг хийх хэрэгтэй гэдгийг бүү мартаарай. Энэ нь танд учрах хохирлын хэмжээг багасгах юм. Эдгээр үйлчилгээг түргэн хугацаанд шийдвэрлэх, цагийг тань хэмнэх аргыг сонгох нь зүйтэй;

Ослын нөхцөл байдлыг баримтжуулах: Зам тээврийн ослын дараагаар үүссэн нөхцөл байдал, учирсан хохирлыг баримтжуулж боломжит бүх өнцгөөс зураг, бичлэг хийх шаардлагатай. Үүний зэрэгцээ зам, замын тэмдэглэгээ, гэрлэн дохио, эргэн тойрныхоо орчны зургийг дарахаа мартуузай. Учир нь Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 2% нь замын нөхцөл байдлаас үүдэлтэй байдаг;

Ослын газраас холдохгүй байх: Зам тээврийн осолд өртсөн тохиолдолд хоёр тал эмнэлгийн тусламж авахаас бусад шаардлагаар хэргийн газраас холдохгүй, орчин нөхцөлийг өөрчлөхгүй байх үүрэгтэй. Ингэснээр, асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх, буруутанд хариуцлага хүлээлгэх зэрэг чухал ач холбогдолтой юм. Хөнгөн хэлбэрийн тохиолдол ч гэсэн тээврийн хэрэгсэлд далд гэмтэл бий болох, эрүүл мэндэд нүдэнд үл үзэгдэх хохирол үүсэн байж болзошгүй гэдгийг бүү мартаарай.

Зам дээр зогсохоос зайлсхийх хэрэгтэй: Хөдөлгөөнд оролцож буй бусад жолооч нар ослын дохио, ослын тэмдэглэгээг анзааралгүй дахин нэг зам тээврийн осол гаргах эрсдэлтэй байдаг. Иймд та тээврийн хэрэгслээс буух шаардлагатай тохиолдолд анхаарал болгоомжтой байж, мөн бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахаас зайлсхийж замын зах хэсэгт байрлаж зогсохыг зөвлөж байна.

Замын хөдөлгөөнийг бие дааж зохицуулахыг оролдох хэрэггүй: Зам тээврийн ослын дараагаар ихэнх тохиолдолд түгжрэл үүсэх хандлагатай байдаг. Зарим үед осолд өртсөн талууд бусад жолооч нарт хөдөлгөөний чиглэл өгч замын ачааллыг бууруулах оролдлого хийдэг. Гэвч энэ нь байдлыг улам бүр дордуулах эрсдэлтэй тул та уг ажлыг тээврийн цагдаагийн албанд

үлдээгээрэй.

Маргаан үүсгэхээс зайлсхийх: Зам тээврийн ослын ихэнх тохиолдол хоёр талын буруутай үйлдлээс үүдсэн байдаг. Ослын дараагаар стрессийн түвшин нэмэгдэж та нөхцөл байдалд бүрэн дүгнэлт хийж чадахгүй байх магадлалтай тул өөрийгөө ослын буруутан гэж хүлээн зөвшөөрөх тохиолдол багагүй гардаг байна. Мэдээж хэрэг хэн ч өөрийгөө ослын буруутан гэж хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүйн дээр, эсрэг талын зүгээс таныг шахалтад оруулах хандлага ч олонтоо ажиглагддаг. Энэ үед тохиромжгүй үг хэллэг хэлж, санаагаа бүрэн илэрхийлж чадаагүйгээсээ үүдэн өөрийгөө ослын буруутан болгох эрсдэлтэй. Бодлогогүй хэлсэн үг таны эсрэг ашиглагдах эрсдэлтэй тул хэний буруу гэдгийг тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагад үлдээгээрэй.

Эмнэлгийн тусламжаас татгалзах хэрэггүй: Хэдийгээр та хүнд бэртэл гэмтэл аваагүй гэдэгтээ бүрэн итгэлтэй байгаа ч хэргийн газарт ирсэн эмнэлгийн байгууллагын үзлэгээс татгалзах хэрэггүй. Хэрэв үзлэгийн дараагаар эмч мэргэжилтнүүд танд эмнэлэг явахыг зөвлөсөн бол заавал тэдний үгэнд ороорой. Учир нь гэмтэл зарим тохиолдолд шууд илэрдэггүй тул илүү нарийн үзлэгт хамрагдах шаардлага бий болно.

Хэрэв ослын газар эмнэлгийн тусламж дуудагдаагүй ч таны толгой, хүзүү, хэвлий хэсэгт өвдөлт мэдрэгдвэл зайлшгүй эмнэлгийн байгууллагад хандах хэрэгтэйг сануулж байна.

Кейс: Зорчигч Галаа онгоцон дотор согтууруулах ундаа хэрэглэн, бусадтай маргалдан, зодоон үүсгэн нислэгт саад учруулсан байна. Нисэх онгоцны ахмад онгоцыг хамгийн ойр онгоцны буудал дээр буулган, цагдаагийн байгууллагад шилжүүлж, эрүүгийн хэрэг үүсгэсэнд Галаа хууль зүйн үндэсгүй зөрчил гаргасан гэж маргаан үүсгэжээ.

Шийдэл: Эрүүгийн хуулийн 27.2-д “зорчигч агаарын хөлгийн нислэгийн үед нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан, нисэх багийн гишүүн, бусад зорчигчтой зүй бусаар харилцсаны улмаас хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хохирол учрах нөхцөлийг бүрдүүлсэн, нислэгийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасан тул эрүүгийн хэрэг үүсгэх үндэстэй.


СЭДЭВ 4. ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРЭГ

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг гэж үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг бүхий албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан эсэргүүцсэн нийгэмд аюултай, гэмт буруутай үйлдэл юм.

Эрүүгийн хуульд зааснаар “Хууль сахиулагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол 2700-14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан байна.

Энэхүү гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг “галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, эсвэл хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол 5400-27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тус тус хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дугаар зүйлд заасан “хууль сахиулагч” гэж:



Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн идэвхтэй үйлдэл байх ба хүч хэрэглэж эсэргүүцсэн үеэс төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Албан үүргээ биелүүлэхтэй холбогдуулан хүч хэрэглэсэн гэж гүйцэтгэж буй албаны үйл ажиллагаа буюу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан хууль сахиулагчийн бие махбодод халдсаныг ойлгоно.

Хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн гэж гүйцэтгэж буй албаны үйл ажиллагаа буюу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан хууль сахиулагчийг болон ойр дотнын хүний эрх, эрх чөлөөг хязгаарлана хэмээн сүрдүүлснийг ойлгоно.

Энэ гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хууль сахиулагчийн хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулж, эсэргүүцэх нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна. хууль сахиулагчийг үүргээ хуульд заасны дагуу шударгаар биелүүлж байгаад нь дургүйцэж, үйл ажиллагааг нь тасалдуулах, саатуулах зорилготой, эсхүл шударга ажилласны нь төлөө өс хонзонгийн сэдэлтэй байж болно.

Энэ гэмт хэргийг галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлдсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол хүндрүүлнэ.

Галт зэвсэг гэж дарийн шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж, амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг ойлгоно.

Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно.

Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.

Хууль сахиулах албаны тоног төхөөрөмжид халдаж үйлдсэн гэж цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх, тагнуулын байгууллагын мөрдөн шалгах, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагчид үүрэг гүйцэтгэхэд нь зориулж олгосон, эсхүл тоноггосон объект, тээврийн хэрэгсэл, холбооны хэрэгсэл, олон хүнд нөлөөлж болон нэг бүрийн тусгай хэрэгсэлд халдаж, булаан авч, эвдэж, гэмтээснийг ойлгоно.

Барилга, байгууламжид халдсан гэж хууль сахиулагчийн үйл ажиллагаа явуулдаг, тийм зориулалтаар урт болон богино хугацаанд байрлах орон сууц, зэвсэг техникийн агуулах, сургалт, дадлагын цогцолбор, түр саатуулах,

цагдан хорих, хорих ангийн байгууламжид халдаж үйлдсэнийг ойлгоно²².

Кейс: Тээврийн цагдаагийн ажилтан Лхагва нэгэн тээврийн хэрэгслийг зогсоон, машиныхаа тээшийг онгойлгон, шалгуулах шаардлага тавихад жолооч эсэргүүцэн, миний хувийн өмч гэж маргаан үүсгэн, улмаар дүрэмт хувцсыг нь уран, толгойн тус газар цохисон байна. Лхагвад эрүүгийн хэрэг үүсгэн шалгахад цагдаагийн ажилтны хувцсыг нь төлөөд өгнө, ганц хоёр цохисон сүртэй гэмтэл учраагүй тул хариуцлага хүлээх үндэсгүй гэжээ.

Шийдэл: Эрүүгийн хуулийн 23.1-д “хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан тул заасан тул эрүүгийн хариуцлага хүлээх үндэстэй.

СЭДЭВ 5. ХУУРАМЧ БАРИМТ БИЧИГ ҮЙЛДЭХ, АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг гэж тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний албаны, жолоодох эрхийн үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм.

Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт үндсэн шинжийг “тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолоодох эрхийн үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун

²² Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –УБ., 2018. 411 дэх тал.

хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”, 23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүндрүүлэх шинжийг “энэ гэмт хэргийг үйлдэж бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тус тус хуульчилсан.



Тусгай зөвшөөрөл гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлнэ²³.

Баримт бичиг гэж цаг хугацаа болон орон зайгаар дамжин хүний буй болгон бэхжүүлсэн мэдээлэл бүхий материаллаг объект юм. Агуулгын хувьд баримт бичиг нь шинжлэх ухаан-техникийн (өгүүлэл, ном, патент, шугам зураг), эрх зүй (тогтоол, зарлиг, гэрээ), удирдлагын (тушаал, захирамж, удирдамж), эсхүл захиргааны улс төрийн, шүүхийн асуудлыг хянан хэлэлцэхэд үндэслэл, нотолгоо, баталгаа болох албан ёсны эх бичвэрийг хэлнэ²⁴.

Эрх олгосон баримт бичиг гэж хууль зүйн үр дагавар буй болгосон тодорхой үйлдэл хийх боломж олгосон²⁵ баримт бичиг юм.

²³ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэг.

²⁴ Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. –УБ., 2008. 66 дахь тал.

²⁵ Нарангэрэл, С. Дурдсан бүтээл. –УБ., 2008. 621 дэх тал.

Үүргээс чөлөөлсөн баримт бичиг гэж тухайн этгээдээс тодорхой үйлдэл хийхийг шаардахаас татгалзсан, түүнээс чөлөөлсөн баримт бичиг юм.

Тамга гэж хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий субъектээс тусгайлан үйлдсэн, баримт бичгийг баталгаажуулан дардаг онцгой төрлийн баталгааны хэрэгслийг хэлнэ. Тамгыг төрийн тамга, төрийн байгууллага, албан тушаалтны хэрэглэх тамга гэж ангилна.

Төрийн тамга нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдгийн нэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны хэрэглэх тамга нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх тухай” зааварт зааснаар зөвхөн дараах төрийн байгууллага, албан тушаалтан тамга хэрэглэнэ. Үүнд:

- Монгол Улсын ерөнхийлөгч;
- Монгол Улсын Их хурал;
- Монгол Улсын Засгийн газар;
- Ерөнхийлөгчийн болон УИХ-ын тамгын газар
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар;
- Монгол Улсын яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, түүнчлэн, үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогддог төрийн байгууллага;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон баг, хорооны Иргэдийн нийтийн хурал;
- Бүх шатны Засаг дарга, засаг даргын тамгын газар;
- Шүүх, прокурор, орон нутгийн байгууллага;
- Монгол Улсын хилийн чандад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул;
- Төрийн архив, нотариат, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага байна.

Төрийн байгууллагын тамга, тэмдэг нь дөрвөлжин хэлбэртэй, түүн дээрх бичээс нь дармал монгол үсгээр бичигдсэн байна. Тамганд соёмбыг дүрслэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд хавсаргасан нэгж хэмжээсийг чанд баримтална.

Тэмдэг гэж тамга, тэмдэг хийлгэх, хэрэглэх талаар Засгийн газраас баталсан зааврын дагуу хийгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, оноосон нэр, өмчийн хариуцлагын ялгаа, иргэн бол эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар байрласан албан бичгийг баталгаажуулах хэрэгсэл юм. Бүх тэмдэг, баталгааны тэмдэгт Цагдаагийн байгууллагаас олгосон регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.

Хэвлэмэл маягт гэж тухайн байгууллагын ажлын онцлогт тохируулан улсын стандарт, тусгай зааврын дагуу үйлдэж, урьдчилан боловсруулж бэлтгэсэн хуудсыг хэлнэ.

Иргэний үнэмлэх гэж аль улсын харьяат иргэн болохыг баталгаажуулж, төрийн эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг хэлнэ²⁶.

Албаны үнэмлэх гэж тухайн иргэнийг аль нэг байгууллагын ажилтан, төлөөлөгч, гишүүн болохыг гэрчлэх баримт бичгийг хэлнэ.

Жолоодох эрхийн үнэмлэх гэж тухайн иргэнийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй болохыг гэрчилсэн баримт бичгийг хэлнэ²⁷. Жолоодох эрх авахын тулд авто тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад хамрагдаж, зохих шалгуурыг хангасан байх шаардлагатай.

Боловсролын үнэмлэх гэж иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшинг гэрчилсэн, эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг хэлнэ.

Боловсролын диплом гэж их, дээд буюу тусгай мэргэжлийн сургууль төгссөн ба холбогдох мэргэжил олгосон, түүнчлэн, эрдмийн зэрэг хүртээсэн тухай баримт бичгийг хэлнэ²⁸.

Гадаад паспорт гэж Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагаас олгосон иргэний гадаадад зорчих эрхийг баталгаажуулсан баримт бичгийг хэлнэ²⁹.

Төрийн шагнал гэж шинжлэх ухаан, танин мэдэхүйн шинэ онцгой туурвил, анхдагч шинэ техник, технологи, урлаг, утга зохиолын гоц содон нэгэн цогц, дан бүтээл туурвисан иргэнд олгох шагналыг ойлгоно³⁰.

Хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн баримт бичиг гэж иргэний хувийн байдал (ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар, иргэншил, үндэс угсаа, төрсөн он, сар, өдөр, нас, оршин суугаа хаяг, амьдралын нөхцөл байдал)-ын талаарх мэдээлэл агуулсан баримт бичгийг

²⁶ Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. –УБ., 2008. 236 дахь тал.

²⁷ Нарангэрэл, С. Дурдсан бүтээл. –УБ., 2008. 200 дахь тал.

²⁸ Нарангэрэл, С. Дурдсан бүтээл. –УБ., 2008. 180 дахь тал.

²⁹ Нарангэрэл, С. Дурдсан бүтээл. –УБ., 2008. 102 дахь тал

³⁰ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 302 дугаар зарлигаар баталсан Монгол Улсын төрийн шагналын дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг

ойлгоно. Тухайлбал, төрсний гэрчилгээ, цэргийн үүрэгтний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэр гэх мэт.

Эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичиг гэж иргэн, хуулийн этгээд тухайн эдийн болон эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй болохыг баталгаажуулсан эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг ойлгоно. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ, газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ гэх мэт.

Энэ гэмт хэрэг нь тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолоодох эрхийн үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан идэвхтэй, гэмт буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.

Хуурамчаар үйлдсэн гэж тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолоодох эрхийн үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг дуурайлган хийх, жинхэнэ баримт бичигт засвар, өөрчлөлт хийснийг ойлгоно.

Хуурамч болохыг мэдсээр байж ашигласан гэж эдгээр баримт бичгийг хуурамч болохыг мэдсээр байж эрх олгуулах, үүргээс чөлөөлүүлэх, давуу байдал үүсгүүлэх, эдийн болон эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах зорилгоор хэрэглэхийг ойлгоно.

Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “энэ гэмт хэргийг үйлдэж бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хүндрүүлэх шинжийг хуульчилж өгсөн.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “ноцтой хохирол, хор уршиг гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно” гэж тайлбарлажээ.

СЭДЭВ 6. ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин байгаль хамгаалах болон амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд зааснаар:



Энэ гэмт хэргийн **халдлагын зүйл** нь амьтан, амьтны гаралтай түүхий эд, эрхтэн, чихмэл байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1-д "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна", 2-д "Монгол Улсын иргэд өмчлүүлснээс бусад газар түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн" гэж тус тус заасан.

Амьтан гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн, агнуурын амьтан гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг ойлгоно.

Ховор амьтан гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг ойлгоно. Монгол Улсын улаан номд зааснаар

ховор амьтанд Дорнын сармаахай, говийн евроази шилүүс, суусар булга, ойн булга, эрээн хүрнэ, хүрэн баавгай, Монгол хулан адуу, зэгсний зэрлэг гахай, Алтайн аргаль, янгир ямаа, хар сүүлтэй, элсний тажийгдахаа, соотон алаг дайхаа, сухайн чичүүл зэрэг хөхтөн, одой галуу, байгалийн нугас, ундар шумбуур, хан бүргэд, ооч ёл, Азийн цууцил, Монгол хулан жороо, хонин тооног, усны бух шувуу, бичил одой бух, зээрд дэглий, манхин галуу, гээзэгт нугас, хуруут хун, Хархираа тогоруу, цагаан сүүл нөмрөг бүргэд, Алтайн хойлог, зэрлэг гургуул, загийн бор шувуу, ойн шийхнүүхэй, шагшуургын шатан сүүлт, өгөөлэй шулганаа, наран хөмрөг, шар элэгт хөмрөг зэрэг шувуу, говийн махир хуруут гүрвэл, тойрмын хонин гүрвэл, толбот могой гүрвэл, ногоон бах, модны мэлхий, дорнодын мэлхий зэрэг хоёр нутагтан, шивэр хилэм, тул, Монгол омуль, зантахай загас-зэрэг загас, Номхон далайн могордугуй амтан, Хар мөрний хавч, голын хавч зэрэг хавч хэлбэртэн, дамнуурга цэнхэр соно, шүтээн цох, Дорнын заарт эвэрт цох, аполлон, эверсманны дэвүүр, штуббендорфын дэвүүр, фэб дэвүүр, Зүүн Сибирийн дэвүүр, махаон дэвүүр, бага тосон одот, эгэл хошуулаг шумбуур, инжирийн шумбуур, бэр цэцэгч шумбуур, голт борын шумбуур, хөвдний үхэр хэдгэнэ, модестус үхэр хэдгэнэ, спорадикус үхэр хэдгэнэ, байгалийн үхэр хэдгэнэ, их эрлэг ялаа зэрэг шавж, дагуурын сувдан хясаа, дэлт танан хясаа, Сэлэнгийн татан хясаа, Монгол татан хясаа зэрэг зөөлөн биетэн хамаарна³¹.

Нэн ховор амьтан гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг ойлгоно. Монгол Улсын Улаан номд зааснаар нэн ховор амьтанд Алтайн чацуулин, шарнад цөөвөр, цоохондой мий, Монгол бөхөн, баданга хүдэр, буган цаа, шивэр молцог хандгай, Хар мөрний молцог зэрэг хөхтөн, борцгор хотон, цагаан тогоруу, цагаан толгойт ямаан сүүл, могойч загалай, бор бүргэд, усны нөмрөг бүргэд, релик цахлай, бахим хошуу хургач, цэн тогоруу, хар тогоруу, жороо тоодгой, зэрэг шувуу, Хар мөрний хилэм, үхэрдэй зэрэг загас хамаарна.

Амьтны гаралтай түүхий эд гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос, зэрэг эд эрхтнийг ойлгоно.

Амьтны чихмэл гэж эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор хийсэн амьтны арьс, үсийг ашиглан уг амьтныг сэргээн бүтээснийг ойлгоно.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан,

³¹ Байгаль орчин ногоон хөгжлийн яам. Монгол Улсын улаан ном. –УБ., 2013. 35-257 дахь тал.

худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн идэвхтэй үйлдэл байна. Энэ гэмт хэргийн үндсэн шинж нь байгаль орчинд хохирол учирсан байхыг шаардахгүй, хууль бусаар ан агнаснаар төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан гэж улсын тусгай хамгаалалттай газар нутагт агнуурын амьтныг агнасан, барьсныг ойлгоно.

Ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсныг ойлгоно.

Ховор амьтныг зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтны эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, тэжээн гаршуулсан, үржүүлснийг ойлгоно.

Ховор амьтны гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нууц багатай, устаж болзошгүй амьтны гаралтай түүхий эдийн зүйлийг өөрийн болон бусдын орон байр, агуулах тээврийн хэрэгсэлд байлгасан, бусдад мөнгө болон бусад зүйлээр зарсан, худалдан авсан, нэг газраас нөгөө газарт зөөж шилжүүлсэн, улсын хилээр нэвтрүүлж, гадаад улсад гаргасан зэргийг ойлгоно.

Ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нууц багатай, устаж болзошгүй амьтны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийснийг ойлгоно. Амьтны цуглуулгад эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс хамаарна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн хүндрүүлэх шинж нь нэн ховор амьтныг зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол хүндрүүлэн зүйлчилнэ.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан,

нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хүндрүүлэх шинжийг хуульчилсан байна.

СЭДЭВ 7. ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГ

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд “зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үндсэн шинж:

Энэ гэмт хэргийн үндсэн шинж нь байгаль орчинд хохирол учирсан байхыг шаардахгүй хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.



Байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших ашиглахтай холбогдсон харилцаа, журмыг зөрчсөн үйлдэл байна.

Энэ гэмт хэргийн **халдлагын зүйл** нь ой мод, мод, модон материал байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү

ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна”, 2-т “Монгол Улсын иргэд өмчлүүлснээс бусад газар түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж тус тус заасан.

Ой гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг хэлнэ.

Мод, модон материал гэж ойгоос бэлтгэсэн мод, гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг ойлгож болно.

Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн гэж сум дундын болон сум, дүүргийн ойн ангиас мод бэлтгэх эрхийн бичиг авалгүйгээр, эсхүл эрхийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлж, эрхийн бичигт зааснаас өөр төрлийн мод, өөр ойгоос бэлтгэснийг ойлгоно.

Мод бэлтгэх эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын нэр, хаяг, бэлтгэх модны төрөл хэмжээ, бэлтгэх, тээвэрлэж дуусах хугацаа, газрын нэрийг заана. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

Гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан гэж иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага нь ойгоос бэлтгэсэн мод, гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг өөр аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа сум дундын болон сум, дүүргийн ойн ангиас гарал үүслийн гэрчилгээ авалгүйгээр тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсныг ойлгоно.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт



Дээрх хүндрүүлэх шинжийг дараах байдлаар тайлбарлаж болно³². Үүнд:

- **Байнга тогтвортой үйлдсэн** гэж хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа хууль бусаар мод бэлтгэх үйлдэл хийснийг ойлгоно.
- **Бүлэглэж үйлдсэн** гэж хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг үйлдэх явцад санаатай хамтран оролцсоныг ойлгоно. Энэ гэмт хэргийг хамтран үйлдэх талаар хэрэг үйлдэхээсээ өмнө урьдчилан тохиролцсон, тохиролцоогүй аль нь ч байж болно.
- **Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд үйлдсэн** гэж Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн ойгоос хууль бусаар мод бэлтгэснийг ойлгоно.
- **Төрийн албан хаагч үйлдсэн** гэж төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээд үйлдсэнийг ойлгоно.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүндрүүлэх шинжийг "энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ" гэж хуульчилжээ.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэж зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэх, тээвэрлэх, худалдах, худалдан авах үйлдэл хийх нь тухайн хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болгох, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ авах төлбөр, хураамжийн зардлыг хэмнэх зэрэг ашиг сонирхлын төлөө үйлдсэнийг ойлгоно.

Хууль бусаар мод бэлтгэх шийдвэрийг хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргасан байж болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

³² Гантулга, С., Энхболд, Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги (сурах бичиг). –Уб., 2018. 447 дахь тал.

Кейс: Иргэн “Б” хүүхдүүдийнхээ хамт хашаандаа жил бүр мод тарих, зүлэгжүүлэх хэвшилтэй, хөрсөнд бохирдол үүсгэхгүйг хичээж тогтоосон хогийн цэгт хог хаягдлаа хаядаг байжээ. Харин хөрш “М” хашаандаа барилга барьж дууссан бөгөөд хог, хаягдлаа гудамд гаргаж асгах, барилгын явцад ухсан газраа буцааж булаагүйгээс хог хаягдал цуглах, муу усаа асгаснаас өмхий үнэртэх зэрэг байдалтай байгааг харсан иргэн “Б” энэ байдлаа засаж залруулах талаар хэлсэн боловч иргэн “М” өөр өөрийн худалдаж авсан хашаандаа өөрийнхөөрөө амьдрах ёстой гэж бухимджээ. Энэ үйл явдалд дүгнэлт хийнэ үү?

Шийдэл: Хөрс хамгаалал, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Иргэн “Б” нь хөрсийг доройтуулж, цөлжилт үүсэх нөхцөл бүрдүүлсэн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, хөрсний бохирдлыг арилгах, нөхөн сэргээх түүнд хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий албан тушаалтнаас шаардах эрхтэй.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх ажлын хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах үүрэгтэй байна. Мөн иргэн “М” нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас хөрсийг доройтуулсан бол хохирлыг арилгаж, хөрсийг нөхөн сэргээх үүрэгтэй байна. Иймд иргэн “М”-н гаргасан үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 7.2-д зааснаар Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хуулийг зөрчсөн үндэслэлтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ЭДЭЛЖ БУЙ ЭТГЭЭДЭД ЗААХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН АГУУЛГА

СЭДЭВ 1. НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил, хүлээлгэх хариуцлага:

Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаясан бол хүнийг 10 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах бөгөөд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архидан согтуурсан, ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хот, суурин газарт биедээ хутга, эсхүл хүний биед гэмтэл учруулж болох тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл авч явсан бол зэвсэг, хэрэгслийг хурааж хүнийг 25 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй юм.

Мөн мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулдаг.

Танхайрах зөрчил хүлээлгэх хариуцлага:

2015 оноос урьд хэрэглэж байсан Эрүүгийн хуульд танхайрах үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялын хариуцлага хүлээлгэж байсан бол 2017 оны эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар танхайн үйлдлийг эрүүгийн хуулиас авч зөрчлийн хуулинд шингээсэн билээ.

Тэгвэл Зөрчлийн тухай хуульд зааснаар олон нийтийн газарт, эсхүл орон байранд хэрүүл маргаан үүсгэж, бусдыг өдөөн хатгаж, бусдын амгалан тайван байдал алдагдуулж, олон нийтийг үл хүндэтгэж, үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулдаг.

Хүний биед халдах зөрчил, хүлээлгэх хариуцлага:

Хүний бие нь анагаах ухаан талаасаа толгой, хүзүү, гар болон сарвуу, хөл, болон тавхайнаас бүрдсэн бие махбодын тогтолцоо юм.

Харин зөрчлийн тухай хуулинд зааснаар хүний биед хохирол

учруулахгүйгээр халдаж зодсон бол 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульчилсан байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлага:

Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Хулгайлах зөрчил, хүлээлгэх хариуцлага:

Хулгайлах гэдэг нь ерөнхий нийтлэг ойлголт бөгөөд зөрчлийн тухай хуулинд хулгайн талаар товч бөгөөд тодорхой тусгаж өгсөн байдаг буюу бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах талаар тусгажээ.

Хөрөнгө завших зөрчил, хүлээлгэх хариуцлага:

Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулдаг.

Эд хөрөнгө устгах, гэмтээх зөрчил, хүлээлгэх хариуцлага:

Эд хөрөнгийн эрх гэдэг бол тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах ба захиран зарцуулах, түүнчлэн эд хөрөнгийн хуваарилалт ба солилцооны талаарх иргэний гүйлгээнд оролцогчдын хооронд үүссэн материаллаг шаардлагатай холбогдсон эрх зүйн харилцааны оролцогчдын субъектив эрх юм.

Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Кейс: Хэсэг залуус цэцэрлэгийн хашаан дотор архи ууж байсныг нэгэн иргэн болих тухай шаардлага тавихад цэцэрлэг амарсан хүн байхгүй, танд хамаагүй гэсэн тайлбар өгчээ.

Шийдэл: Зөрчлийн тухай хуулийн 5.1-д “согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архи дан согтуурсан. бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан тул иргэний шаардлага зүй ёсны байна.

СЭДЭВ 2. НИЙТИЙН ӨМЧ, ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

Зөрчлийн тухай хуулийн Наймдугаар бүлэг буюу Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчилд дараах зөрчлийг багтаасан байна. Үүнд:

Газрын тухай хууль зөрчих:

Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалсан газарт зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь эд хөрөнгөө ашиглах, хамгаалах зорилгоор бусдын газраар дайран өнгөрөх зам, цахилгаан, холбооны, инженерийн шугам татах, гарц гаргах, бусад зориулалтаар бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газар эзэмшигч, ашиглагч газар чөлөөлөх үүргээ тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуульд заасан журмын дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах, шилжүүлэх тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх, эсхүл газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх, эсхүл барьцаалах журам зөрчсөн бол газар эзэмших, ашиглах гэрээг цуцалж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шинээр тариалангийн талбай бий болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг

гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Бэлчээрийг зохистой ашиглах, эсхүл хамгаалах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуульд заасан гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулахаар шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлгүйгээр газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн, барьцаалсан, эсхүл 183 хоногоос дээш хугацаагаар бусдад ашиглуулах журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд хадлан авч дуустал мал бэлчээх, эсхүл тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн газарт мал, амьтан оруулах, бэлчээхийг хориглосон хязгаарлалтыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуульд заасныг зөрчиж:

- Газар эзэмшигч, ашиглагч газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах шаардлагыг биелүүлээгүй;
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглахтай холбогдолтой зураг төсөл боловсруулах, эсхүл шинэ технологи нэвтрүүлэх, эсхүл Монгол Улсад өмнө нь сорьж, шалгаагүй химийн бодис, бордоог газарт хэрэглэхдээ мэргэжлийн эрх бүхий байгууллагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгээгүй;
- Иргэн, хуулийн этгээд нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, эсхүл тоног төхөөрөмж байршуулах, эсхүл үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой, бусад бодисыг газрын доор хадгалах, эсхүл булах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтгүйгээр гүйцэтгэсэн;
- Газрыг бохирдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Түүнчлэн:
- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан;
- Улсын тусгай хэрэгцээний газарт дур мэдэн үйл ажиллагаа явуулсан;

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэхээр зааснаас бусад газарт газар эзэмшсэн;
- Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн газрыг эзэмшиж, ашиглаж байсан иргэн, хуулийн этгээд газрыг нөхөн сэргээгээгүй, сайжруулаагүй;
- Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын тухай хуульд заасныг зөрчиж:

- Албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар усны давхар нэр хэрэглэсэн;
- Газар усны албан ёсны нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулсан, эсхүл бусад хэлний дуудлагаар галиглан бичсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх бүхий этгээдэд хуульд заасан зориулалтаар уг газрыг ашиглахад нь санаатайгаар саад учруулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах болон эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг биелүүлээгүй бол газар эзэмших, ашиглах гэрээг цуцалж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих:

Газар өмчлөх эрх бүхий иргэн хуульд заасан үүрэг, эсхүл хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол хүнийг таван нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Өмчилж авсан газраа кадастрын, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусад иргэний өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон журам, эсхүл барьцааны гэрээ, эд хөрөнгө өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тогтоосон цэгт байрлуулсан заагийн цэг, геодезын цэг, тэмдэгтийг хамгаалах, бүрэн бүтэн байлгах, эсхүл газрын төлөв байдал, чанарыг дордуулахгүй байх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа хэлбэрээр саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Өмчийнхөө газрыг ашиглах явцад барилгын, экологийн, ариун цэврийн, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын болон бусад холбогдох стандарт, дүрэм, журам, шаардлагыг сахиж мөрдөх, эсхүл өмчийн газрынхаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн зардлаар 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгүүлж байх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, эсхүл өмчийн газраа Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29.1-д заасан зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлсэн, ашиглуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлсөлсөн, дамжуулан түрээсэлсэн бол түрээсийн гэрээг цуцалж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зохиогчийн эрхийн тухай хууль зөрчих:

Зохиогчийн эрхийн тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Түүнчлэн эрх эзэмшигчийн таних тэмдгийн хамт бичигдсэн зүйлийг өөрчилсөн, устгасан, хууль бусаар өөрчилсөн, тараасан, хилээр нэвтрүүлсэн, нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлс, хууль бусаар олсон орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хамтын удирдлагын байгууллага батлагдсан төлбөрийн хэмжээнээс илүү хэмжээгээр төлбөр хураан авсан, батлагдсан төлбөр дээр нэмэлт төлбөр ногдуулсан, хуульд заасан тайлан, мэдээг зохих хугацаанд ирүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаагаа ашгийн төлөө болгож өөрчилсөн, хууль болон хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, зохиогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой зөрчиж үйл ажиллагаа явуулсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг үл харгалзан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Патентын тухай хууль зөрчих:

Патентаар хамгаалагдсан бүтээгдэхүүнийг, эсхүл патентаар хамгаалагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн, импортолсон, худалдах санал гаргасан, худалдсан, хэрэглэсэн, эсхүл эдгээр зорилгоор хадгалсан, эсхүл патентаар хамгаалсан аргыг хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Барааны тэмдэг эзэмшигчийн эрх, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих:

Барааны тэмдэг эзэмшигчийн эрх, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө завших:

Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

СЭДЭВ 3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ

Зөрчлийн тухай хуульд зааснаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэхдээ хохирогчийн хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар хуульчилсан.



Тэгвэл хуваарьт болон дундын эд хөрөнгө гэдэг нь Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллага буюу Улсын бүртгэлийн байгууллагад гэр бүл болсноо бүртгүүлж, гэр бүл болсонтой холбоотойгоор, тухайн гэр бүлийн хамтын аж амьдрал, ахуйн хэрэгцээг хангах зорилгоор өмчлөгдсөн, гэр бүлийн гишүүдийн аль нэгний, эсхүл тэдгээрийн ах дүү төрөл, садангийн буюу төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг тухайн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх, дундын эд хөрөнгөд гэж ойлгодог байна.

Өөрөөр хэлбэл гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгийг хэлдэг байна.

Хууль зүйн талаасаа бол эзэмших эрх гэдэг нь хүсэл зоригийн дагуу ямар нэгэн эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүсдэг байна. Харин энэхүү дундын хөрөнгийг гэр бүлийн хэн нэгэн гишүүн өөрийн хэрэгцээндээ хэрэглэх эсхүл ашиг олох гэх мэт үйлдэл хийхтэй нь холбогдуулан хориглох, эрх олгохгүй дангаараа шийдвэрлэж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн эдийн засгийн болон сэтгэл зүйн хүчирхийллийн хэлбэр юм.

Хамтын амьдрал зохиосныхоо хувьд гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй байдаг гэсэн ойлголт юм.

Эрэгтэй эмэгтэй хосууд гэр бүл зохиох буюу насанд хүрсэн хүмүүсийн сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн бүрэлдэн бий болж хуульд заасны дагуу төрийн байгууллагад бүртгүүлэх явдал нь хамтын амьдралын жаргал, зовлонг хамтдаа туулах гэр бүл болсны илрэл юм.

Энэхүү гэрлэлтээр холбогдсон нөхөр, эхнэр нь зохион бий болгосон гэр бүлдээ харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх ёстой байдаг.

Гэвч энэхүү тэгш эрхийн гэсэн ойлголтыг умартан гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн өөртөө давуу байдлыг бий болгох бусад гишүүдийг дорд үзэх зэрэг бусармаг байдлаас шалтгаалан гэр бүлийн гишүүдэд хүчирхийлэл үйлдэх явдал нийгэмд байсаар байна.

Энэ нь нэг талаас хууль эрх зүйн мэдлэг дутмаг, нөгөө талаас гэр бүлийн ариун нандин мөн чанарыг гүйцэд ойлгоогүйтэй холбоотой байдаг байна.

Гэр бүлийн шийдвэр бол хамтын шийдвэр байх учиртай. Өөрөөр хэлбэл ярилцаж, тохиролцож, гишүүд дэмжсэний үндсэн шийдвэр гаргаж байх ёстой гэсэн үг юм.

Шийдэлд хүрээгүй, өөрийн үзэл бодлыг тулгасан, айлган сүрдүүлсэн шийдвэр бүхэн үнэ цэнгүй байгаад зогсохгүй гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр болдог гэдгийг анхаарах учиртай.

Монголын уламжлалт зан заншилд ч гэсэн энэхүү гэр бүлийн харилцааны талаар сургаж, зөвлөж, зааж залруулсан байдгийг дурдах нь зүйтэй юм. Тийм ч учир зүйр цэцэн үгээр хэлэхдээ "Жанжин хэдий мэдэлтэй ч хууль ёс дагана, заан хэдий том ч замын аяыг дагана" гэж хэлдэг нь учиртай.

Яагаад гэвэл гэр бүлд ажил хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогын ихэнх хувийг бүрдүүлж байгаа нь эрх мэдэлтэй, гэр бүлийн гишүүдэд дээрэнгүй байхын нэр бус хамтын амьдралын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаагийн нэгэн илрэл гэдгийг ухамсарлах явдал юм. Түүнээс биш гэр бүлийн гишүүдийн хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдаж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хууль зөрчихийг хууль эрх зүйтэй төр, нийгэм, иргэд хэрхэвч зөвшөөрөхгүй гэдгийг санах учир байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн дунд ихэнх гаргадаг алдаа бол гэр бүлийн харилцаа, хандлага, итгэлцэл, ойлголцол гэдгийг мартаж өсгүй.

Гэр бүлийн харилцаа бол зорилго дүүрэн, санал нийлсэн, дэмжсэн болон тэтгэсэн шинж бүхий зүйл бөгөөд нийгмийн бэрхшээл бол эмгэг биш, харин бүхий л амьдралын нэг хэсэг байдаг. Хандлага гэдэг нь нөхцөл байдал болон бусад хүмүүсийг тааламжтай ба тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх үнэлэлт юм. Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага мэдрэгддэг. Хандлага үйлдэл болохдоо бодлоор дамжин илэрдэг учир сайхан харилцаа хандлагыг бий болгож сайхан хандлага зөв бодлыг төрүүлдэг байна.

Харин итгэл бол хүн чанарын нэг шалгуур, ёс суртахуун ёс зүйн нэн чухал хэмжүүр гэж үздэг. Итгэл бол аугаа их хүч ч гэж хэлдэг. Хайр сэтгэл, гэр бүл нь итгэл дээр оршин тогтнож батжин бэхжих бөгөөд хүнд итгэж явах их сайхан, хүмүүсийн итгэлийг хүлээнэ гэдэг бүр ч сайхан зүйл гэж хэлдэг. Бусдад итгэдэггүй хүн өөрийгөө тарчлаан зовоож, сэтгэлийн мөнхийн зовлон эдэлдэг төдийгүй гэр бүлийн гишүүдийн үл итгэлээс шалтгаалан хууль зөрчих цаашлаад гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээх хүртэл асуудалтай тулдаг гэдгийг анхаарах учиртай юм.

Кейс: Иргэн Д, С нар нь гэр бүлээ батлуулаад 18 жилийг ардаа үлджээ. Эхнэр С гэр бүл болохдоо өвөг эцгээс өв уламжлан ирсэн хуучин бор авдрыг нандигнан хадгалж ирсэн боловч нөхөр Д нэг өдөр энэ хуучин муу авдар миний гэрийн өнгө үзэмжийг гутаагаад байгаа учир гаргаж хаях, эсхүл хүнд өгөх талаар

эхнэртэйгээ ярилцаад тодорхой шийдэлд хүрээгүй удаа дараа маргалдсан байна.

Нөхөр Д, эхнэрийн эзгүйд нөгөө хуучин бор авдрыг үл таних хүнд өгчээ. Энэхүү үйлдлийн мэдсэн эхнэр ихэд гомдож, авдраа олох зорилгоор цагдаагийн байгууллагад өргөдөл гаргасан тул цагдаагийн байгууллагаас шалгаж авдрыг олж өгөхөөс гадна шүүхээс нөхөр Д-г 7 хоног баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Шийдэл: Цагдаагийн эрх бүхий ажилтан гомдлыг шалган шийдвэрлэх явцад иргэн Д Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.4-д зөрсөн гэж үзэж зөрчлийн хэргийг шүүхэд шилжүүлсэн, шүүхээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн нь тогтоогдсон тул тохирох шийтгэл оногдуулах үндэслэлтэй байна.

СЭДЭВ 4. ЖАГСААЛ, ЦУГЛААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ ЗӨРЧИХ

Жагсаал цуглаан зохион байгуулах нь ардчилсан нийгмийн иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх нэг хэлбэр мөн боловч төрийн хуулиар хориглосон газарт, эрх бүхий байгууллагад бүртгүүлэлгүйгээр, эсхүл мэдэгдэл хүргүүлснээс хойш хуульд заасан хугацаа өнгөрөөгүй байхад жагсаал, цуглаан зохион байгуулсан, эсхүл жагсаал, цуглааны явцад түүний зорилгыг өөрчилж хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуульд заасан шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалтай.




Харин хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад хөндлөнгөөс санаатайгаар саад учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй.

Хууль бус жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй.

Бусдыг өдөөн хатгаж гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.

Хуулиар зөвшөөрсөн буюу журмын дагуу зохион байгуулагдаж буй жагсаал цуглаанд согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалтай байна.

Харин жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогчийг хууль бус үйлдлийн хувьд:




Кейс: Иргэн Л, Б, Х нар нь жагсаал цуглаан зохион байгуулах талаар эрх бүхий байгууллагад бүртгүүлэн хуулийн дагуу зохион байгуулж байжээ. Гэтэл иргэн Д жагсаалд оролцох явцдаа олны анхаарлыг өөртөө татах, сайн үүлдрийн нохойгоо сурталчлах зэрэг зорилгоор жагсаал болох газарт очсонд цагдаагийн байгууллагын алба хаагч саатуулж, зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах үндэслэлтэй гэсэн шаардлага тавьсан тул энэ үйлдэлд иргэн Д миний үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхэд халдсан үйлдэл байна хэмээн гомдол гаргажээ.

Шийдэл: Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлд зааснаар “Жагсаал цуглаанд оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан байна.

СЭДЭВ 5. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ

Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалттай.



Мөн эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлдэг байна.

Энэхүү хүнд нөхцөлд эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалттай.


Гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалан хүн бүр өөрийн үүрэгтэй оролцож байж бусдад болон өөрт учирсан хүнд хэцүү нөхцөл байдлыг даван туулах, урьдчилан сэргийлэх учиртай бөгөөд Гамшгаас хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хүнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулдаг байна.



СЭДЭВ 6. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ЗӨРЧИХ

Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх, эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх, эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах зэрэг олон эрхүүдийг хуулиар хамгаалсан онцгой анхаарал хандуулах шаардлагатай субъект юм.

Тэгвэл энэхүү эрхийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд нь:



Хүүхдийг:


- Аливаа төлбөр, хураамжийг төлөөгүй үндэслэлээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хууль бусаар хязгаарласан;
- Өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан;
- Өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор хууль бусаар хүүхдийн

нэрийг барьж, ашиг олох, эсхүл амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр төлбөл зохих хүүхдийн тэтгэмж төлөх үүрэгтэй.



СЭДЭВ 7. БЭЛГИЙН ДАРАМТ УЧРУУЛАХ



Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ илэрхийлэх нь зөрчлийн шинжтэй үйлдэл юм.

Хэрэв бэлгийн дарамтыг дээрх хэлбэрээр учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ

Ял, шийтгэлийн зорилгыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд “эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, **гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд** оршино”, Зөрчлийн тухай хуульд “шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс **урьдчилан сэргийлэх**, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино” гэж хуульчилсан байна.

Хүний өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд хэвшмэл зуршил болсон үйлдлийг зан үйл гэж үздэг. Зан үйлийг өөрчлөхөд тухайн асуудлыг хэр чухалд авч үзэж байна гэдэг хандлага их нөлөөлдөг. Хандлага нь мэдлэг дээр үндэслэгддэг. Зарим хүмүүс өөрсдийн зан үйлийг өөрчилж чаддаг бол зарим хүмүүсийн зан үйлийг өөрчлөхийн тулд бусдын оролцоо, дэмжлэг, нотолгоонд суурилсан үр дүнтэй арга барил, үнэн зөв мэдээлэл, мэдлэгт тулгуурлан нөлөөлөх шаардлагатай байдаг.

Ял эдэлж буй болон баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйл, сэтгэл зүйн чиг хандлагад нөлөөлөх, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагатай, ухамсарт иргэн болж төлөвшүүлэхийн тулд зан үйлд нөлөөлөх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах шаардлага гардаг.

Нэг. Сургалтын хэлбэр:

1. Танхимын сургалт (ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулна); Танхимын сургалтыг лекц, семинар, дасгал ажил, хэлэлцүүлэг, харилцан ярилцах хэлбэрээр зохион явуулна.
2. Зайны сургалт (олон нийтийн сүлжээ, программ хангамж ашиглан зохион байгуулна).

Хоёр. Сургалтын хугацаа:

Сургалтын 8 цагийг 1 багц цагт тооцох ба суралцагч улиралд 1-ээс доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байна. Сургалтын 1 цаг нь 45 минут байна. Эрх зүйн сургалт нийт 30 цаг буюу лекц-18, семинар-12 цаг байхаар журамд тусгагдан, дараах байдлаар явуулахаар төлөвлөсөн байдаг.

Гурав. Сургалтын хэрэглэгдэхүүн:

1. Тухайн хичээлийг судлахад шаардагдах хууль тогтоомж, ном, сурах бичиг, гарын авлага, үзүүлэх, тараах материал, кейс, удирдамж, компьютер, проектор, бусад техник хэрэгсэл.

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго: Хорих ял эдэлж буй хоригдол, баривчлах шийтгэл эдэлж буй баривчлагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан болон зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн ойлголт, хор уршиг, хүлээлгэх хариуцлагын талаарх ерөнхий мэдлэг олгон, аливаа үйл ажиллагаанд үүднээс хууль зүйн үүднээс шийдвэр гаргах чадвар эзэмшин, хууль ёс, дэг журмыг сахидаг хандлага төлөвшүүлэхэд оршино.

Зорилт:

1. Иргэний эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарлан дээдлэх чадвартай байх;
2. Гэмт хэрэг, зөрчлөөс ангид байх;
3. Нийтийн хэв журмыг сахин мөрддөг, хүний нэр төр, алдар хүндийг дээдэлдэг байх;
4. Хууль, журам даган зөв мөрдөн амьдрах учир холбогдлыг танин мэдсэн байх;
5. Хууль бус үйлдэл, эс үйлдлийн хор уршгийг танин мэдсэн байна.

ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ҮР ДҮН

Хорих ял эдэлж буй хоригдол, баривчлах шийтгэл эдэлж буй баривчлагдсан этгээд, зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд эрх зүйн сургалтыг явуулснаар дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

д/д	Хүрэх үр дүн	Шалгуур
1.	Мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хуулийн ойлголт, мөн чанар, үйлчлэх хэмжээ хязгаар; - Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл, ангилал; - Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийн тухай, түүнд хүлээлгэх хариуцлага; - Зөрчлийн тухай хуулийн ойлголт, мөн чанар, үйлчлэх хэмжээ хязгаар; - Зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрөл, ангилал; - Зарим төрлийн зөрчлийн шинж, хүлээлгэх хариуцлага; - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж; - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд тавих тухай хууль тогтоомж; - Хүүхдийн эрхийн хангах хууль тогтоомжийн ерөнхий мэдлэг эзэмшинэ.
2.	Чадвар	- Дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүйгээр нийгэмд зөв амьдрах чадвар эзэмшинэ.
3.	Хандлага	- Нийтээр дагаж мөрдөх хууль, тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг сахин мөрддөг хандлага төлөвшсөн байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж:

- Үндсэн хууль. 1992 он
- Эрүүгийн хууль. 2015 он
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. 2002 он
- Зөрчлийн тухай хууль. 2017 он
- Гэр бүлийн тухай хууль. 1999 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 2017 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016 он
- Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2019 он

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага:

- Адъяабазар, Д. Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт (I-дэвтэр). -УБ., 1998
- Болдбаатар, Ж. Эрүүгийн эрх зүй. -УБ., 2000
- Баярсайхан, Б., Жанцан, С., Энхнасан, Ж., Сумъяацэрэн, Д. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). -УБ., 2011
- Болдбаатар, Ж. Эрүүгийн эрх зүйн үндэс. -УБ., 2004
- Болдбаатар, Ж. Эрүүгийн эрх зүй. -УБ., 2008
- Болдбаатар, Ж. Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). -УБ., 2016
- Булган, Д., Хулан, Б. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил. -УБ., 2022
- Жанцан, С. Эрүүгийн хариуцлага. -УБ., 2006
- Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). -УБ., 2011
- Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (гэмт хэргийн тухай сургаал) 1-р боть. -УБ., 2009
- Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (ялын тухай сургаал) 2-р боть. -УБ., 2014

- Нарангэрэл, С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги. -УБ., 2006.
- Нарангэрэл, С. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн асуудал. - УБ., 1985.
- Нарангэрэл, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. -УБ., 1999.
- Нарангэрэл, С. Монголын ба дэлхийн эрүүгийн эрх зүйн тогтолцоо. -УБ., 2001.
- Нарангэрэл, С. Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003,
- Нарангэрэл, С. Эрдэнэбат, Г. Эрүүгийн эрх зүй гарын авлага.- УБ., 2007.
- Нарангэрэл, С. Эрх зүйн толь бичиг. -УБ., 2009.

Гурав: Цахим хаяг:

- www.legalinfo.mn
- www.mojha.gov.mn